

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 7421 дүгээрт бүртгэв

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар А/408

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, экспортлох, хадгалах, устгах, түгээх, худалдах үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг нэгдүгээр, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар (Н.Эрдэнэбаяр)-т үүрэг болгосугай.

3. Эмийн цахим жорын мэдээний санд нэмэлт хийж, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорыг цахимжуулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (С.Нармандах)-д үүрэг болгосугай.

4. Тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68, 2016 оны А/184, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/327, 2019 оны А/180, 2020 оны А/21, 2021 оны А/66, А/781 дүгээр тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

САЙД

Ж.ЧИНБҮРЭН

*Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10 дугаар сарын
27-ны өдрийн А/408 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

**ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭХ
МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ ЭМИЙГ ҮЙЛДВЭРЛЭХ,
ИМПОРТЛОХ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ, ЭКСПОРТЛОХ, ХАДГАЛАХ,
УСТГАХ, ТҮГЭЭХ, ХУДАЛДАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ
ЖУРАМ**

Нэг.Нийтлэг зүйл

1.1.Энэхүү журмын зорилго нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, тэдгээрийн түүхий эд (цаашид “мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм” гэх)-ийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, экспортлох, хадгалах, устгах, түгээх, худалдах үйл ажиллагаатай холбоотой асуудлыг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиудын хүрээнд зохицуулж, хяналт тавихад оршино.

1.2.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, экспортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх, худалдахад энэ чиглэлээр аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/-тэй байна.

1.3.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, тэдгээрийн түүхий эдийг хадгалах, устгахад Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль болон уг хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас баталсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, бодис, тэдгээрийн түүхий эд болон бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг хадгалах, устгах журмыг мөрдөнө.

1.4.Энэхүү журмын 1.2-т заасан тусгай зөвшөөрөл бүхий эм ханган нийлүүлэх байгууллага, үйлдвэр нь энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан эмээр эрүүл мэндийн байгууллага, эмийн санг тасралтгүй, жигд, хүртээмжтэй, сонголт хийх боломжийн үнээр хангах зарчмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

**Хоёр.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох,
экспортлох**

2.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт эмчилгээний зориулалтаар хэрэглэх тухайн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жилийн хэрэгцээг үндэслэн Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага импорт, экспортын мэдүүлгийг тухай бүр 6 сарын хугацаагаар олгоно.

2.2.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг урьдчилан тогтоосон хэрэгцээнээс нэмж импортлох, экспортлох шаардлагатай

тохиолдолд энэ тухай Эрүүл мэндийн яаманд мэдэгдэж, тус яамнаас Олон улсын мансууруулах бодисын хяналтын зөвлөлөөр шийдвэрлүүлсэн тохиолдолд импорт, экспортын мэдүүлэг олгоно.

2.3.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, эмийн түүхий эд, эмийн дээж, стандарт бодисын импорт, экспортын мэдүүлэг хүсэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

2.3.1.импорт, экспортын мэдүүлэг авах хүсэлт;

2.3.2.мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм импортлох-ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийн хуулбар;

2.3.3.экспортлогч, импортлогч талтай байгуулсан албан ёсны гэрээ;

2.3.4.эм, эмийн түүхий эдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.3.5.импорт, экспортын мэдүүлэг хүссэн өргөдөл /маягтын дагуу/;

2.3.6.нэхэмжлэх;

2.3.7.баталгааны хуудас.

2.4.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импорт, экспортын мэдүүлэг хүссэн өргөдөл болон баримт бичгийг хүлээн авснаас хойш Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажлын 5 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

2.5.Мэдүүлэг олгогч өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар шалгуулах, магадлах, дүгнэлт гаргуулах шаардлагатай тохиолдолд мэдүүлэг хүссэн өргөдлийг шийдвэрлэх хугацааг ажлын 10 хоног хүртэл сунгаж болно.

2.6.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импорт, экспортын мэдүүлгийг Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжийн дарга хянаж, баталгаажуулна.

2.7.Энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан маягтын дагуу мансууруулах эмийн импорт, экспортын мэдүүлгийг шар, сэтгэцэд нөлөөт эмийн импорт, экспортын мэдүүлгийг ногоон өнгийн А4 цаасан дээр 5 хувь үйлдэж, импортлогч, экспортлогчид 2 хувийг, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар, Гаалийн ерөнхий газарт тус тус 1 хувийг хүргүүлнэ.

2.8.Импортлох, экспортлох үйл ажиллагааг импорт, экспортын мэдүүлгийн хүчинтэй хугацаанд багтаан гүйцэтгээгүй болон нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн мэдүүлэг авсан байгууллагын дахин гаргасан хүсэлтийг үндэслэн өмнөх мэдүүлгийг хураан авч, шинээр импорт, экспортын мэдүүлэг олгоно.

2.9.Импортлогч нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг улсын хилээр нэвтрүүлж, өөрийн агуулахад татан авсан тухай бүр 7

хоногийн дотор Цагдаагийн ерөнхий газрын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, бодис хариуцсан нэгж болон Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

2.10.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн тухай бүр тухайн Гаалийн байгууллага нь Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад 7 хоногийн дотор мэдэгдэнэ.

2.11.“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн импорт, экспортын мэдүүлэг”-ийг журмын нэгдүгээр хавсралтад заасан маягаар, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн импорт, экспортын мэдүүлэг хүсэх өргөдөл”-ийг журмын хоёрдугаар хавсралтад заасан загварын дагуу хөтөлнө.

Гурав.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг үйлдвэрлэх

3.1.Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын стандарт хангасан, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг үйлдвэрлэнэ.

3.2.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн үйлдвэрлэлд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага стандарт, ургамлын гаралтай түүхий эд ашиглах, тарималжуулах тохиолдолд Байгалийн ургамлын тухай хууль 10, 13 дугаар зүйлийг тус тус мөрдөнө.

3.3.Тусгай зөвшөөрөл бүхий эмийн үйлдвэр нь үйлдвэрлэсэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг зөвхөн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм импортлох-ханган нийлүүлэх, худалдах тусгай зөвшөөрөлтэй байгууллагад нийлүүлнэ.

Дөрөв.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг ханган нийлүүлэх, түгээх, худалдах, хэрэглэх

4.1.Тусгай зөвшөөрөл бүхий эм ханган нийлүүлэх байгууллага нь мансууруулах эмийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон мансууруулах эм худалдах тусгай зөвшөөрөлтэй эмийн санд нийлүүлэх бөгөөд тухайн байгууллагын захиалга, гэрээг үндэслэнэ.

4.2.Эм хангамжийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг дамжуулах болон солилцохыг хориглоно.

4.3.Мансууруулах эмийг эмнэлгийн нөхцөлд, хөнгөвчлөх эмчилгээний үед, шаардлагатай тохиолдолд эмчийн бичсэн жорын дагуу гэрийн эмчилгээнд болон яаралтай тусламж үйлчилгээнд хэрэглэнэ.

4.4.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага

мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн захиалгыг бусад эмээс тусад нь хийж, эмнэл зүй эрхэлсэн дэд захирлаар баталгаажуулна.

4.5.Мансууруулах эмийг эмчилгээнд хэрэглэхэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах хяналтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.5.1.сувилагч нь эмчлэгч эсхүл жижүүрийн эмчийн хяналтын дор мансууруулах эмийг өвчтөнд хэрэглэнэ;

4.5.2.мансууруулах эмийг үйлдвэрийн савласан хэмжээнээс бага тун, хэмжээгээр өвчтөнд хэрэглэх тохиолдолд илүү гарсан эмийн үлдэгдлийг ажлын цагаар эмчлэгч эмчийн, ажлын бус цагаар жижүүрийн /тухайн эмчилгээ үйлчилгээ үзүүлсэн/ эмчийн хяналтын дор тухай бүр хөндлөнгийн гэрч байлцуулан баримтжуулж, журмын дагуу устгана;

4.5.3.мансууруулах эмийг өвчтөнд хэрэглэсэн бол тухайн эмийн нэр, цувралын дугаар, хэрэглэсэн аргыг өвчтөний түүхэнд тодорхой бичиж, баталгаажуулан, хэрэглэсэн эмийн хоосон тун шил, шахмал эмийн савыг тоо ширхгээр эмийн санд эргүүлэн тушааж, тэмдэглэл хөтөлнө;

4.5.4.эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эмийн сан эсвэл эм зүйн алба нь мансууруулах эмийн хоосон тун шил, шахмал эмийн савыг тоо ширхгээр буцаан авсан тухай тусгай бүртгэл хөтлөн, тоо хэмжээнээс хамаарч комисс томилон, хөндлөнгийн гэрч байлцуулан устгана.

4.6.Мансууруулах эм худалдах тусгай зөвшөөрөлтэй эмийн сангийн жор баригч мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэхийг үндэслэн шаардагдах мэдээллийг агуулсан цахим эсвэл цаасан эмийн жорын дагуу заасан тоо, хэмжээгээр олгож, бүртгэл хөтлөн, хэрэглэх арга, гаж нөлөөнөөс сэргийлэх талаар дэлгэрэнгүй зааварчилгаа өгнө.

4.7.Эмийн сан нь хүлээн авсан, олгосон, устгасан мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн нэр, цувралын дугаар, огноо болон зарцуулалтын бүртгэл хөтөлж, бүртгэлийг 1 жил хадгалж, байгууллагын архивд шилжүүлнэ.

Тав.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жор бичих, жорын маягтын хангалт

5.1.Эмийн найрлагад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис орсон бол эмч эмчилгээний тохирох тунгаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн цаасан эсвэл цахим жор бичнэ.

5.2.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорыг бичихэд эмийн жор бичилтийг зохицуулсан Монгол Улсын стандартыг мөрдөнө.

5.3.Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягыг Монгол Улсын стандартад

заасан загварын дагуу хэвлүүлэн, дугаарлаж /индекс/, тухайн нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагуудад түгээнэ.

5.4.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг тухайн байгууллагын захиалга болон өмнө авсан жорын маягтын зарцуулалтын тайланг үндэслэн олгоно.

5.5.Мансууруулах эмийн жорын маягтын дугаар нь тухайн аймаг, нийслэлийн Засаг захиргааны нэгжийн код болон 5 оронтой тоо, сэтгэц нөлөөт эмийн жорын маягт нь дээрх код болон 6 оронтой тооноос бүрдэнэ.

5.6.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт орсон тухай бүр Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь цахим жорын системд өөрчлөлт оруулах хүсэлтийг өөрчлөлт орсноос хойш ажлын 10 өдрийн дотор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.

5.7.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн цахимаар бичигдсэн жорын мэдээлэл, эмийг борлуулсан эмийн сангийн мэдээллийг төрийн мэдээллийн ХУР системд нийлүүлэх, холболтын ажлыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар хариуцан зохион байгуулна.

Зургаа.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импорт, экспорт, түгээлт зарцуулалтын бүртгэл, тайлан

6.1.Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн дараа оны хэрэгцээг өмнөх жилийн татан авалт, тухайн жилийн захиалга зэргийг тооцон гаргаж, Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн жилийн 1 дүгээр улиралд багтаан ирүүлнэ.

6.2.Эрүүл мэндийн байгууллага болон эм хангамжийн байгууллага нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хөдөлгөөнийг энэ журамд заасан маягтын дагуу үнэн зөв хөтөлнө. Үүнд:

6.2.1.нийтийн үйлчилгээтэй эмийн сан нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын, зарцуулалтын болон устгалын бүртгэл, тайлан;

6.2.2.эрүүл мэндийн байгууллагын эмийн сан нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын, устгалын болон хэвтэн эмчлүүлэгчдэд хэрэглэсэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын бүртгэл, тайлан;

6.2.3.эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, эмийн түүхий эдийн орлого, зарлага, зарцуулалтын болон устгалын бүртгэл, улирлын тайлан;

6.2.4.эрүүл мэндийн байгууллагын мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын бүртгэл, тайлан;

Маягт №01

**Нийтийн үйлчилгээтэй эмийн санд хөтлөгдөх мансууруулах
болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын бүртгэл**

Эмийн сангийн нэр _____

№	Огноо	Эмийн нэр, тун хэмжээ, хэлбэр	Цувралын дугаар	Нийлүүлэгчийн нэр	Баримтын дугаар	Эмийн тоо хэмжээ		
						орлого	зарлага	эцсийн үлдэгдэл

Маягт №02

**Нийтийн үйлчилгээтэй эмийн санд хөтлөгдөх мансууруулах
болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын бүртгэл**

Эмийн нэр, тун хэмжээ, хэлбэр _____

№	Огноо	Жорын индекс	Жор бичсэн огноо, эмчийн нэр	Үйлчлүүлэгчийн нэр	Онош, олон улсын өвчний ангилал кодоор	Үйлчлүүлэгчийн регистрийн дугаар	Олгосон			Жор баригчийн нэр
							эмийн цувралын дугаар	эм хэрэглэх хоног	эмийн тоо хэмжээ	

Маягт №03

**Эрүүл мэндийн байгууллагын эмийн санд хөтлөгдөх
мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын
бүртгэл**

Эмийн нэр, тун хэмжээ _____ Хэмжих нэгж _____

Огноо	Эхний үлдэгдэл	Орлого			Зарлага		Эцсийн үлдэгдэл
		тоо	цувралын дугаар	нийлүүлэгчийн нэр	тоо	тасаг, нэгж	

Маягт №04

Эрүүл мэндийн байгууллагад хэвтэн эмчлүүлэгчдэд хэрэглэсэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын бүртгэл

Байгууллага, тасгийн нэр _____
Эмийн нэр, тун хэмжээ _____ Хэмжих нэгж _____

№	Огноо	Эмчлүүлэгчийн			Орлого	Цувралын дугаар	Зарлага			Буцаалт	Үлдэгдэл	Эмчлэгч эмчийн нэр	Сувилагчийн нэр
		түүхийн дугаар	овог, нэр, гэрийн хаяг	онош, олон улсын өвчний ангилал кодоор			хэрэглэсэн тун	хэрэглэсэн эмийн тоо хэмжээ	хэрэглэсэн давтамж				

Маягт №05

Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэрт хөтлөгдөх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын бүртгэл

Эм (эмийн түүхий эд)-ийн нэр, тун хэмжээ, хэлбэр _____ Хэмжих нэгж _____

№	Огноо	Орлого				Зарлага				Үлдэгдэл тоо
		тоо	цувралын дугаар	импортын мэдүүлгийн дугаар	нийлүүлэгчийн нэр	олгосон огноо	байгууллагын нэр	тоо	баримтын дугаар	

Маягт №06

Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, эмийн сангийн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын тайлан

Байгууллагын нэр _____ оны дугаар улирлын тайлан

№	Эм/эмийн тvvхий эдийн нэр,	Тун хэмжээ	Хэмжих нэгж	Эхний үлдэгдэл	Орлого	Цувралын дугаар	Нийлүүлэгчийн нэр	Зарлага	Эцсийн үлдэгдэл

Маягт №07

Эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн санд хөтлөгдөх мансууруулах болон сэтгэц нөлөөт эм/түүхий эдийн устгалын бүртгэл

Байгууллагын нэр _____ оны сарын өдөр

№	Эм, эмийн тvvхий эдийн нэр	Хэмжих нэгж	Цувралын дугаар	Устгасан	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын улсын байцаагчийн дүгнэлтийн дугаар	Шийдвэр гаргасан эрхийн актын дугаар, огноо	Тайлбар

Маягт №08

Эрүүл мэндийн байгууллагын мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын бүртгэл

Байгууллагын нэр _____ оны сарын өдөр

№	Жорын индекс	Үйлчлүүлэгчийн овог, нэр	Регистрийн дугаар	Онош, ICD11 ангилал код	Жорд бичсэн эмийн нэр, тун хэмжээ	Эмийн хэлбэр	Жор бичсэн эмчийн овог, нэр

Маягт №09

**Эрүүл мэндийн байгууллагын мансууруулах болон сэтгэцэд
нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын тайлан**

Байгууллагын нэр _____ оны сарын өдөр

Жорын маягт хүлээн авсан огноо	Жор бичсэн эмчийн нэр	Хүлээн авсан жорын маягтын		Зарцуулсан жорын маягтын		Үлдэгдэл жорын	
		индекс	тоо	индекс	тоо	индекс	тоо
1.Мансууруулах эмийн жорын маягт							
2.Сэтгэц нөлөөт эмийн жорын маягт							

Маягт №10

**Хэвлүүлсэн, түгээсэн мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн
жорын тайлан**

Эрүүл мэндийн газрын нэр _____ оны сарын өдөр

№	Хэвлүүлсэн жорын тоо	Олгосон байгууллагын нэр	Жор бичсэн эмч, тасаг, нэгжийн нэр	Олгосон жорын маягт		Үлдэгдэл жорын	
				индекс	тоо	индекс	тоо
1.Мансууруулах эмийн жорын маягт							
2.Сэтгэц нөлөөт эмийн жорын маягт							

Маягт №11

**Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэрийн
мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн импортын тайлан**

Байгууллагын нэр _____ ... оны ... дугаар/дүгээр улирлын тайлан

Байгууллагын нэр _____ оны хэрэгцээний тайлан

№	Эмийн худалдааны нэр	Эмийн олон улсын нэршил	Эмийн тун	Эмийн хэлбэр	Үйлдвэрлэгчийн нэр	Улс	Тоо /ширхэг/	Цэвэр бодис	Нийт цэвэр бодис
1.Мансууруулах эм									
2.Сэтгэц нөлөөт эм									

6.3.Нийтийн үйлчилгээтэй болон эрүүл мэндийн байгууллагын эмийн сангууд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын тайланг хагас жилээр гарган, 7 дугаар сарын 10-ны болон дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор харьяа аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт ирүүлэх бөгөөд Эрүүл мэндийн газар тайланг нэгтгэн, Цагдаагийн ерөнхий газрын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, бодис хариуцсан нэгж болон Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ажлын 10 хоногт багтаан тус тус хүргүүлнэ.

6.4.Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр импортолсон, үйлдвэрлэсэн, экспортолсон эм, эмийн түүхий эдийн тайланг улирал болон жилээр гарган улирал бүрийн эхний сарын 05-ны дотор Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад; жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор Цагдаагийн ерөнхий газрын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, бодис хариуцсан нэгж болон Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус тус хүргүүлнэ.

6.5.Эрүүл мэндийн байгууллага нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын тайланг улирал болон жилээр гарган, дараа оны 1 дүгээр сарын 05-ны дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

6.6.Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь хэвлүүлж, түгээсэн болон зарцуулсан мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жорын тайланг /маягт №10/ дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор Цагдаагийн ерөнхий газрын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, бодис хариуцсан нэгж болон Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

6.7.Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэрээс ирүүлсэн импортолсон, үйлдвэрлэсэн, экспортолсон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмийн түүхий эдийн зарцуулалт, устгалын тайлан болон хэрэгцээг Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нэгтгэж НҮБ-ын “Мансууруулах эмийн тухай” 1961 оны Нэгдсэн Конвенц, “Сэтгэц нөлөөт бодисын тухай” 1971 оны Конвенц, “Мансууруулах эм болон сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг” 1988 оны Конвенцод заасан хугацаанаас 15 хоногийн өмнө Эрүүл мэндийн яаманд хүргүүлнэ.

6.8.Эрүүл мэндийн яам нь НҮБ-ын “Мансууруулах эмийн тухай” 1961 оны Нэгдсэн Конвенц, “Сэтгэц нөлөөлөх бодисын тухай” 1971 оны Конвенц, “Мансууруулах эм болон сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг” 1988 оны Конвенцод нэгдэн орсон Талын үүргийн хүрээнд холбогдох тайланг конвенцод заасан хугацаанд нь Олон улсын

мансууруулах бодисын хяналтын зөвлөлд хүргүүлнэ.

6.9.Импортлолсон, үйлдвэрлэсэн, экспортлолсон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмийн түүхий эдийн зарцуулалт, ашиглалт, устгалын тайланг Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нэгтгэж Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуульд заасны дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний хороонд хүргүүлнэ.

Долоо.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хэрэглээнд хяналт тавих

7.1.Эрүүл мэндийн байгууллагын мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хадгалалт, хэрэглээ, зарцуулалт, устгал, жор бичилт, жорын маягтын зарцуулалтад тус байгууллагын чанарын алба хяналт тавьж ажиллана.

7.2.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх, худалдах эмийн санд эмийн сангийн эрхлэгч, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэрт чанарын менежер мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хадгалалт, түгээлт, зарцуулалт, устгалд хяналт тавьж ажиллана.

7.3.Энэхүү журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар зохион байгуулна.

7.4.Журмын хэрэгжилтэд Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавьж ажиллана.

7.5.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг хууль бусаар үйлдвэрлэсэн, импортлолсон, ханган нийлүүлсэн, экспортлолсон, хэрэглэсэн, зарцуулсан, түгээсэн, худалдсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээг авна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, тэдгээрийн түүхий эдийг
үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, экспортлох, хадгалах,
устгах, түгээх, худалдах үйл ажиллагааг зохицуулах журмын
нэгдүгээр хавсралт

**МАНСУУРУУЛАХ /СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ ЭМИЙН ИМПОРТ/
ЭКСПОРТЫН МЭДҮҮЛЭГ**
Import/Export license of Narcotic/Psychotropic Drugs

Экспортлогчийн нэр, хаяг / Name and address of exporter:		Зөвшөөрөл олгогч / Competent authority:			
		Зөвшөөрлийн дугаар / Authorization number:			
Импортлогчийн нэр, хаяг / Name and address of importer:		Гэрээний дугаар / Contract number:		Огноо / Date of issue:	
		Илгээх улс / Country of export:		Гэрээт улс / Contracting country:	
		Гарал үүсэл / Country of origin:		Хүлээн авах улс / Country of destination:	
Тээврийн төрөл / Mode of transport:			Нэмэгдэл тайлбар / Supplementary details Эмчилгээний зориулалтаар / Medical use Эрдэм шинжилгээний зориулалтаар/ Scientific use		
Хилийн боомт / Port of entry:					
Эмийн олон улсын нэр / International non-proprietary name	Эмийн худалдааны нэр / Brand name	Бүртгэлийн дугаар / Registration №	Тун хэмжээ / Dosage	Эмийн хэлбэр, хэмжих нэгж / Dosage form, unit	Тоо Хэмжээ / Quantity
Цэвэр бодисын агууламжийн хэмжээ / The quantity expressed in terms of anhydrous base content					
Зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын хугацаанд хүчинтэй / License is valid within 6 months of the issue					
Олгосон / Issued by					
Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар					
Medicine and Medical Devices Regulatory Agency of Mongolia					
Огноо / Date					
Тэмдэг / Stamp /					
Гарын үсэг / Signature					

*Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, тэдгээрийн түүхий эдийг
үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, экспортлох, хадгалах,
устгах, түгээх, худалдах үйл ажиллагааг зохицуулах журмын
хоёрдугаар хавсралт*

**МАНСУУРУУЛАХ /СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ ЭМИЙН ИМПОРТ/
ЭКСПОРТЫН МЭДҮҮЛЭГ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ**
**Application form for import/export license of Narcotic/Psychotropic
Drugs**

Экспортлогчийн нэр, хаяг / Name and address of exporter:		Гэрээний дугаар / Contract number:		Он, сар, өдөр / Date:			
Импортлогчийн нэр, хаяг / Name and address of importer:		Илгээх улс / Country of export:		Гэрээт улс / Contracting country:			
		Гарал үүсэл / Country of origin:		Хүлээн авах улс / Country of destination:			
Тээврийн төрөл / Mode of transport:							
Хилийн боомт / Port of entry:		Нэмэгдэл тайлбар / Supplementary details Эмчилгээний зориулалтаар / Medical use Эрдэм шинжилгээний зориулалтаар / Scientific use					
Эмийн олон улсын нэр / International non-proprietary name	Эмийн худалдааны нэр / Brand name	Бүртгэлийн дугаар / Registration №	Тун хэмжээ / Dosage	Эмийн хэлбэр, хэмжих нэгж / Dosage form, unit	Тоо Хэмжээ / Quantity	Нэгж үнэ / Unit price	
Өмнөх зөвшөөрлийн гүйцэтгэл / Use of previous authorization							
Хавсрагдсан баримт / Attached documents 1. 2. 3. 4.							
Хянасан / Revised by Өргөдөл гаргасан / Applied by Байгууллагын / Иргэний нэр Name of organization / person Албан тушаалын нэр / Title Гарын үсэг / Signature Харилцах утас / Telephone							 Танилцсан / Seen by Тусгай тэмдэглэл / Note Он сар өдөр / Date

*Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн
А/408 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

**ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭХ
МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ ЭМИЙН ЖАГСААЛТ**

А. Мансууруулах эмийн жагсаалт

№	Олон улсын нэршил	Химийн нэршил
1	Бензетидин	1-(2-бензилоксиэтил)-4-фенилпиперидин-4-карбоны хүчлийн этилийн эфир
2	Гидрокодон	дигидрокодеинон
3	Гидроморфон	Дигидроморфинон
4	Дигидрокодеин	морфины уламжлал
5	Кодеин	3-метилморфин
6	Леворфанол	(-)-3-гидроксид-N-метилморфинан
7	Морфин	(4R,4aR,7S,7aR,12bS)-3-метил-2,4,4a,7,7a,13-гексагидро-1H-4,12- метанобензофур[3,2-e]изокинолин-7,9-диол
8	Метадон	6-диметиламино-4,4-дифенил-3-гептанон
9	Оксикодон	14-гидроксидигидрокодеинон
10	Оксиморфон	14-гидроксидигидроморфинон
11	Фентанил	1-фенетил-4-N-пропиониланилинопиперидин
12	Петидин	1-метил-4-фенилпиперидин-4-карбоны хүчлийн этилийн эфир
13	Тримеперидин	1,2,5-триметил-4-фенил-4-пропиониксипиперидин
14	Суфентанил	N-[4-(метоксиметил)-1-[2-(2-тиенил)этил]-4-пиперидил] пропионанилид

Б. Сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт

№	Олон улсын нэршил	Химийн нэршил
1	Аллобарбитал	5,5-диаллилбарбитурын хүчил
2	Алпразолам	8-хлоро-1-метил-6-фенил-4H-s-триазоло[4.3-a][1,4] бензодиазепин
3	Амобарбитал	5-этил-5-изопентилбарбитурын хүчил
4	Атомоксетин	(-)(3R)-N-метил-3-(2-метилфенокси)-3-фенилпропан-1-амин (гидрохлорид)
5	Барбитал	5,5-диэтилбарбитурын хүчил
6	Бромазепам	7-бromo-1,3-дигидро-5-(2-пиридил)-2H-1,4-бензодиазепин-2-он
7	Бупренорфин	21-циклопропил-7-а-[(S)-1-гидроксид-1,2,2-триметилпропил]-6,14-эндостано-6,7,8,14-тетрагидроорипавин
8	Глутетимид	2-этил-2-фенилглутаримид
9	Диазепам	7-хлоро-1,3-дигидро-1-метил-5-фенил-2H-1,4-бензодиазепин-2-он
10	Делоразепам	7-хлоро-5-(o-хлорфенил)-1,3-дигидро-2H-1,4-бензодиазепин-2-он

11	Залеплон	N-(3-(цианопиразоло[1,5-а]пиримидин-7-ил)фенил)-N-этилацетамид
12	Золпидем	N,N,6-триметил-2-р-толилимидазол[1,2-а]пиридин-3-ацетамид
13	Зопиклон	(RS)-6-(5-хлорпиридин-2-ил)-7-оксо-6,7-дигидро-5Н-пирроло[3,4-б]пиразин-5-ил 4-метилпипиразин-1-карбоксилат
14	Кетамин	2-(метиламино)-2-(2-хлорфенил)-циклогексаноны гидрохлорид
15	Клоназепам	5-(о-хлорфенил)-1,3-дигидро-7-нитро-2Н-1,4 бензодиазепин-2-он
16	Клотиазепам	5-(о-хлорфенил)-7-этил-1,3-дигидро-1-метил-2Н-тиэно[2,3-е]-1,4 диазепин-2-он
17	Лоразепам	7-хлоро-5-(о-хлорфенил)-1,3-дигидро-3-гидрокси-2Н-1,4-бензодиазепин-2-он
18	Мепробамат	2-метил-2-пропил-1,3-пропандиолдикарбамат
19	Медазепам	7-хлоро-2,3-дигидро-1-метил-5-фенил-1Н-1,4-бензодиазепин
20	Метаквалон	2-метил-3-о-толил-4(3Н)-квиназолинон
21	Метамфетамин	(+)-(S)-N,а-диметилфенетиламин
22	Метилфенидат	метил-а-фенил-2-пиперидины ацетат
23	Мидазолам	8-хлоро-6-(о-фторфенил)-1-метил-4Н-имидазо[1,5-а][1,4]-бензодиазепин
24	Нитразепам	1,3-дигидро-7-нитро-5-фенил-2Н-1,4-бензодиазепин-2-он
25	Оксазепам	7-хлоро-1,3-дигидро-3-гидрокси-5-фенил-2Н-1,4-бензодиазепин-2-он
26	Пентобарбитал	5-этил-5-(1-метилбутил)барбитурын хүчил
27	Пентазоцин	(2R*6R*11R*)-1,2,3,4,5,6-гексагидро-6,11-диметил 3-(3-метил-2-бутенил)-2,6-метано-3-бензазоцин-8-ол
28	Пиназепам	7-хлоро-1,3-дигидро-5-фенил-1-(2-пропинил)-2Н-1,4-бензодиазепин-2-он
29	Секобарбитал	5-аллил-5-(1-метилбутил)барбитурын хүчил
30	Трамадол	транс-(±)-2-[(диметаламино)метил]-1-(3-метоксифенил)циклогексанол
31	Фенобарбитал	5-этил-5-фенилбарбитурын хүчил
32	Флуразепам	7-хлоро-1-[2-диэтиламино]этил]-5-(о-фторфенил)-1,3-дигидро-2Н-1,4-бензодиазепин-2-он
33	Флуниотразепам	5-(о-фторфенил)-1,3-дигидро-1-метил-7-нитро-2Н-1,4-бензодиазепин-2-он
34	Хлордизаепоксид	7-хлоро-2-(метиламино)-5-фенил-3Н-1,4-бензодиазепин-4-оксид
35	Циклобарбитал	5-(1-циклогексен-1-ил)-5-этилбарбитурын хүчил
36	Эфедрин	L-1-фенил-2-метиламинопропанол

Энэхүү жагсаалтад заагдсан нэршил бүхий бодисууд, түүний давснуудыг агуулсан эм, эмийн түүхий эдийн бүх тун хэмжээ, хэлбэр болон худалдааны нэршлийг хамруулж ойлгоно.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 7422 дугаарт бүртгэв

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар А/773

Өлгий

ИНТЕРНЕТ КАФЕ БОЛОН ЦАХИМ ТОГЛООМЫН ГАЗРЫН АЖИЛЛАХ ЦАГИЙН ХУВААРЬ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлтийн 28.1.11, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Интернет кафе болон цахим тоглоомын газрын ажиллах цагийн хуваарь батлах тухай”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү захирамжийг захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга (Ө.Хуралай)-д даалгасугай.

3. Журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн мөрдөж, холбогдох хууль тогтоомж стандартыг хангуулж хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт, Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Ө.Танат)-т, Хүнс хөдөө, аж ахуйн газар (Б.Нургулан)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” А/543 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Е.ЗАНГАР

*Аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын
23-ны өдрийн А/773 дугаар захирамжийн хавсралт*

**ИНТЕРНЭТ КАФЕ БОЛОН ЦАХИМ ТОГЛООМЫН ГАЗАР АЖИЛЛАХ
ЦАГИЙН ХУВААРЬ**

Д/д	Үйл ажиллагааны нэр	Үйл ажиллагаа явуулах цагийн хуваарь	Улирлын онцлогоор ажиллах хуваарь	Үйл ажиллагаа явуулах цагийн хуваарь	
				Эхлэх цаг	Дуусах цаг
1	Интернэт кафе болон цахим тоглоомын газар	10-18 хүртэлх насны хүүхдэд	04 дүгээр сарын 01-нээс 10 дугаар сарын 01 хүртэл	09:00	18:00
		Насанд хүрэгчдэд	Улирал харгалзахгүй	09:00	22:00

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 7423 дугаарт бүртгэв

БОЛОВСРОЛЫН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 11 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар А/544

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 63 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хосмог сургалт зохион байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан журмыг 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж ажиллахыг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлуудад үүрэг болгосугай.

3.Хосмог сургалтыг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Дээд, мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газар (Н.Нарангэрэл), хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т тус тус даалгасугай.

4.Журмын хэрэгжилтэд 2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт даалгасугай.

5.Энэхүү журмыг баталсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн “Түр журам батлах тухай” А/330 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

П.НАРАНБАЯР

*Боловсролын сайдын 2025 оны 11 дүгээр сарын
11-ний өдрийн А/544 дүгээр тушаалын хавсралт*

ХОСМОГ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Боловсролын ерөнхий хуулийн 8.4, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 3.1.10, 11.3 дахь заалтад үндэслэн хосмог сургалт зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Хосмог сургалтын зорилго нь суралцагчийг ажиллангаа суралцах, суралцангаа ажиллах боломжийг бүрдүүлэх, төгсөгчийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.3.Хосмог сургалт зохион байгуулахад хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн, тэгш оролцоог хангасан, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлд суурилсан байх зарчмыг баримтална.

Хоёр.Хосмог сургалтын зохион байгуулалт

2.1.Хосмог сургалтыг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага (цаашид “сургалтын байгууллага” гэх), аж ахуйн нэгж, байгууллага, суралцагч хамтран мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

2.2.Хосмог сургалтад Хөдөлмөрийн тухай хуулийн 63.1-д заасан гэрээгээр ажиллаж байгаа дагалдан суралцах ажилтан (цаашид “суралцагч” гэх) хамрагдана. Дагалдан суралцах ажилтан нь суурь болон түүнээс дээш боловсрол эзэмшсэн насанд хүрсэн иргэн байна.

2.3.Хосмог сургалтад хамрагдахыг хүссэн иргэн тухайн оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор аж ахуйн нэгж, байгууллагад хүсэлтээ гаргаж бүртгүүлнэ.

2.4.Аж ахуйн нэгж, байгууллага энэхүү журмын 2.2-т заасан суралцагчийг хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагын дагуу бүртгэж баталгаажуулна.

2.5.Аж ахуйн нэгж, байгууллага хосмог сургалт хэрэгжүүлэх хүсэлт, энэхүү журмын 2.4-т заасны дагуу бүртгэсэн суралцагчийн мэдээллийг сургалтын байгууллагад тухайн оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор албан бичгээр хүргүүлнэ.

2.6.Сургалтын байгууллага аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан өөрийн удирдлагаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

2.7.Сургалтын байгууллага тухайн хичээлийн жилийн хосмог сургалтын элсэлтийн хяналтын тооны саналыг Боловсролын ерөнхий

хуулийн 26.1.22-т заасан журмын дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж батлуулна.

2.8.Сургалтын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, суралцагч хамтран дагалдан суралцах гуравласан хөдөлмөрийн гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г байгуулна.

2.9.Энэхүү журмын 2.8-д заасан гэрээнд хосмог сургалтын хөтөлбөрийг хавсаргана.

2.10.Аж ахуйн нэгж, байгууллага хосмог сургалтыг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 3.1.12-т заасан дадлагажуулагчаар удирдуулна.

2.11.Сургалтын байгууллага болон аж ахуйн нэгж, байгууллага хосмог сургалтын зохион байгуулалт, гүйцэтгэл, чанар, үр дүн, суралцагчийн идэвх, оролцооны талаар тайлан, мэдээллийг хөтөлж, мэдээлэл солилцож хамтран ажиллана.

2.12.Сургалтын гүйцэтгэл, чанар, үр дүнд сургалтын байгууллага болон аж ахуйн нэгж, байгууллага хамтран хяналт тавина.

2.13.Хосмог сургалтын үнэлгээг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8.1-д заасан журмын дагуу зохион байгуулна.

2.14.Энэхүү журмын 2.13-т заасан үнэлгээний дүнг үндэслэн Боловсролын ерөнхий хуулийн 9.3-т заасан журмын дагуу төгсөгчид зохих түвшний боловсролын баримт бичгийг олгоно.

2.15.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан агуулгын дагуу сургалтын байгууллага дээр зохион байгуулах онолын болон сургууль дээрх дадлага сургалтын зардлыг сургалтын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага дээр зохион байгуулах онолын болон үйлдвэрлэлийн дадлага сургалтын зардал, үнэлгээний зардлыг аж ахуйн нэгж, байгууллага тус тус хариуцна.

Гурав.Хосмог сургалтын хөтөлбөр

3.1.Хосмог сургалтын хөтөлбөрийг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.12-т заасан шаардлага, загварын дагуу сургалтын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага хамтран боловсруулж, сургалтын байгууллагын захирлаар батлуулан хэрэгжүүлнэ.

3.2.Хосмог сургалтын хөтөлбөрөөр үйлдвэрлэлийн орчин, ажлын байранд шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг онолын болон дадлага сургалтаар дамжуулан суралцагчид эзэмшүүлнэ.

3.3.Хосмог сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн хэрэгцээ, шаардлага, технологийн шинэчлэл, хүний нөөцийн хэрэгцээнд нийцүүлэн сургалтын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага хамтран тасралтгүй сайжруулж шинэчилнэ.

3.4.Сургалтын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний үр дүнг үндэслэн шаардлагатай тохиолдолд хөтөлбөрийн агуулга, цагийн бүтэц, арга зүйд тохируулга хийж болно.

Дөрөв.Хосмог сургалтын оролцогч талууд

4.1.Хосмог сургалт зохион байгуулах, үйл ажиллагаанд оролцох аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү журмын 3.1-д заасны дагуу сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцож, хөдөлмөрийн зах зээл дэх тухайн байгууллагын үйлдвэрлэлийн онцлогт шаардлагатай мэргэшил, ур чадварын эрэлт, хэрэгцээг тодорхойлон, холбогдох судалгаа, мэдээллээр сургалтын байгууллагыг хангана.

4.2.Аж ахуйн нэгж, байгууллага хосмог сургалт зохион байгуулахад шаардагдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль, дүрэм, журамд нийцсэн тоног төхөөрөмж, материалаар хангаж, орчныг бүрдүүлнэ.

4.3.Сургалтын байгууллага нь сургалтын зохион байгуулалт, чанар, гүйцэтгэлтэй холбоотой аж ахуйн нэгж, байгууллагад зохих санал, зөвлөмж хүргүүлж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна.

4.4.Суралцагч нь сургалтын зохион байгуулалттай холбогдуулан сургалтын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагад санал тавьж, хүсэлт гарган шийдвэрлүүлж болно.

4.5.Суралцагч нь хосмог сургалтын явцын болон төгсөлтийн үнэлгээнд хамрагдаж эзэмшсэн мэдлэг, ур чадвараа үнэлүүлж баталгаажуулна.

4.6.Аж ахуйн нэгж, байгууллага суралцагчийг төгссөний дараа үргэлжлүүлэн ажлын байраар хангах, тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлж болно.

Тав.Бусад

5.1.Сургалтын байгууллага болон аж ахуйн нэгж, байгууллага хамтран хосмог сургалтын чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлж болно.

5.2.Сургалтын байгууллага болон аж ахуйн нэгж, байгууллага хосмог сургалтын зохион байгуулалт, энэхүү журмын 2.8-д заасан гэрээний хэрэгжилт, сургалтын чанарт хяналт тавина.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 7424 дүгээрт бүртгэв

**СҮХБААТАР АЙМГИЙН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 11 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар А/16

Баруун-Урт

“ЭМ ЭС КИ ЭНД ТИ У” ХХК-НИЙ ТАРИФЫГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дахь заалт, 26 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор батлагдсан журам, “Эм Эс Ки энд Ти У” ХХК-ний 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 4/1 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Уулбаян суманд үйл ажиллагаа явуулдаг “Эм Эс Ки энд Ти У” хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/-ний эзэмшил дэх дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Эм Эс Ки энд Ти У” ХХК-ний захирал /Е.Цэвээнжав/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах, хяналт тавьж ажиллахыг Зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны гишүүн /Ш.Мандахнар/-д даалгасугай.

ДАРГА

Ш.МАНДАХНАР

ГИШҮҮД

Г.СУГАРАА
Б.МӨНХСҮЛД

*Сүхбаатар аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн
2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/16 дугаар
тогтоолын хавсралт 1*

**“ЭМ ЭС КИ ЭНД ТИ У” ХХК-НИЙ ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Уулбаян суманд үйл ажиллагаа явуулах “Эм Эс Ки энд Ти У” ХХК-ний эзэмшил дэх дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон тус сумын хэрэглэгчдэд /төсөвт байгууллага, аж ахуйн нэгжүүд, айл өрхийн хэрэглэгч/ борлуулах дулааны эрчим хүчний тариф /НӨАТ-гүй/-ыг ангилалаас хамааран төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

Д/д	ХЭРЭГЛЭГЧДИЙН АНГИЛАЛ		ХЭМЖИХ НЭГЖ	ТАРИФ /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагуудын халаалт		Төг/м3	2530
2	Аж ахуйн нэгж байгууллагын халаалт		Төг/м3	2000
3	Айл өрхийн халаалт		Төг/м2	1200
4	Төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийн хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	93908,76
		Тогтмол	Төг/м3	522,29

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 7425 дугаарт бүртгэв

ХОВД АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 11 дүгээр
сарын 19-ны өдөр

Дугаар 05

Ховд

“БАДАМЛАХ ДӨЛ” ХХК-НИЙ ҮНЭ ТАРИФЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, Жаргалант сумын төвийг дулаанаар хангагч “Бадамлах дөл” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Жаргалант сумын төвийг дулаанаар ханган ажиллаж буй “Бадамлах дөл” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуй нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний акт”-д бүртгүүлж, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны гишүүн /Б.Гомбосүрэн/, Бадамлах дөл ХХК-ний ерөнхий захирал /Д.Сурмаажав/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тариф батлах тухай 2023 оны 12 дугаар сарын 25 өдрийн 29 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах, хяналт тавьж ажиллахыг орон тооны бус гишүүд Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Анхбаяр/, Эрчим хүчний улсын байцаагч /З.Батзаяа/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Б.ГОМБОСҮРЭН

ГИШҮҮН

Б.АНХБАЯР

ГИШҮҮН

З.БАТЗАЯА

Зохицуулах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын
19-ны өдрийн 05 тоот тогтоолын хавсралт

**ДУЛААНЫ “БАДАМЛАХ ДӨЛ” ХХК-Н ЭЗЭМШЛИЙН ДУЛААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Ховд аймгийн Жаргалант сумын “Бадамлах дөл” ХХК-ний эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг /нөат-гүй/ ангилалаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

№	Хэрэглэгчдийн ангилал		Хэмжих нэгж	Тариф / нөат-гүй/
1	Төсөвт байгууллагын эзэлхүүнээр тооцох халаалт		Төг/м3	2956.8
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах		28661.0
3		Тогтмол	Төг/м3	2362.0
4	Үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын эзэлхүүнээр тооцсон халаалт		Төг/м3	2268
5	Үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын хэмжүүрээр тооцсон халаалт	Хувьсах		27770.0
6		Тогтмол	Төг/м3	1693.3
7	Төсөв, ҮААНБ-ын хэрэглээний халуун ус халаасан дулаан		Төг/хүн	4000.0
8	Айл өрхийн халаалт /дотуур байр, подваль, “00”-ын өрөөний халаалт хамаарна/		Төг/м3	900.0
9	Ахуйн хэрэглээний халуун ус халаасан дулаан		Төг/м3	3000.0
10			Төг/хүн	9000.0

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 7426 дугаарт бүртгэв

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2025 оны 10 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар А/283

Улаанбаатар
хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Олон улсын гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу батлах дүрмүүд болох “ИНД-131 Агаарын хөлгийн түрээс”-ийг нэгдүгээр хавсралтаар, “ИНД-138 Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа”-г хоёрдугаар хавсралтаар, “ИНД-144 Нисэхийн хангамжийн байгууллага, гэрчилгээжүүлэлт”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Иргэний нисэхийн дүрмийг мөрдөж, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийн шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр), энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2010 оны “Дүрэм батлах тухай” 160 дугаар тушаалын 16, 19 дүгээр хавсралт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны “Иргэний нисэхийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай” А/71 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын
16-ны өдрийн А/283 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

ИНД - 131 Агаарын хөлгийн түрээс

131.1. Зорилго

(а) Энэ дүрмээр агаарын хөлгийг арилжааны нислэг үйлдэх зорилгоор түрээслэх, түрээслүүлэх үйл ажиллагааг зохицуулна.

131.3. Нэр томьёо ба товчлол

(а) Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-1 Нэр томьёоны тайлбарт багтсан.

131.5. Агаарын хөлгийн түрээсийн зохицуулалт

(а) Агаарын хөлгийн түрээс нь дараах хэлбэртэй байна:

(1) “нойтон түрээс” буюу агаарын хөлгийг нисэх багтай нь түрээслэх;

(2) “хуурай түрээс” буюу агаарын хөлгийг нисэх баггүйгээр түрээслэх;

(3) “холимог түрээс” буюу агаарын хөлгийг нисэх багийн зарим гишүүнтэйгээр түрээслэх.

(b) Агаарын хөлгийн хуурай түрээсийн үед тухайн агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагааны хяналт түрээслэгч талд байх ба үйл ажиллагаа нь түрээслэгчийн эзэмшиж буй Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд явагдана.

(c) Агаарын хөлгийн нойтон, эсхүл холимог түрээсийн үед тухайн агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагааны хяналт түрээслүүлэгч талд байх ба үйл ажиллагаа нь түрээслүүлэгчийн эзэмшиж буй Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээгээр олгогдсон зөвшөөрөл, хязгаарлалтад нийцсэн байна.

(d) Холимог түрээс бол түрээслэгчийн зүгээс томилох багийн гишүүдийн ур чадвар болон үйл ажиллагааны хяналт нь түрээслүүлэгчийн үйл ажиллагааны заавар журамд нийцсэн байна.

131.7. Хамрах хүрээ

(а) Энэ дүрмээр түрээсийн дараах үйл ажиллагааг зохицуулна:

(1) Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийг агаарын тээвэрлэгч түрээслэх болон түрээслүүлэх;

(2) Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийг гадаад улсын агаарын тээвэрлэгчдэд түрээслүүлэх;

(3) Агаарын тээвэрлэгч гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгийг түрээслэх.

131.9. Түрээсийн зөвшөөрөл хүсэх

(а) Агаарын хөлөг түрээслэхээр төлөвлөж буй этгээд нь түрээсийн

зөвшөөрөл хүссэн өргөдлийг САА24131/01, эсхүл САА24131/02 маягтын дагуу бөглөж, гэрээнд гарын үсэг зурахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч (цаашид “Дарга” гэх)-д хүргүүлнэ.

(b) Өргөдөлд энэ дүрмийн 131.15-д шаардсан мэдээлэл, түрээсийн гэрээний төсөл болон холбогдох бусад баримт бичгийг хавсаргасан байна.

(c) Түрээсийн агаарын хөлөг нь гадаад улсад бүртгэлтэй тохиолдолд тухайн агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар болон нислэгийн ашиглалтын шаардлагуудад хамаарах мэдээллийг солилцохоор Даргаас бүртгэгч улс руу түрээсийн зөвшөөрөл олгож байгаа нөхцөл болон түрээсийн бусад асуудлаар мэдэгдэл хүргүүлнэ.

131.11. Түрээсийн зөвшөөрөл

(a) Энэ дүрмийн 131.15-д заасан шаардлагыг хангасан агаарын тээвэрлэгчид Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Дарга түрээсийн үйл ажиллагааны зөвшөөрөл олгоно.

(b) Агаарын хөлгийг бүртгэгч улсаас хүсэлт гаргасан тохиолдолд, Дарга түрээсийн зөвшөөрлийн хуулбарыг тухайн улсад хүргүүлнэ.

(c) Түрээсийн зөвшөөрлийг агаарын тээвэрлэгчийн Үйл ажиллагааны тодорхойлолтод нь бичилт хийх хэлбэрээр олгох бөгөөд дараах мэдээллийг тусгана:

- (1) түрээсийн гэрээ байгуулсан талуудын нэр;
- (2) түрээсийн агаарын хөлгийн эзэмшигч, эсхүл өмчлөгчийн нэр;
- (3) түрээсийн агаарын хөлгийн маяг, улсын бүртгэлийн дугаар, үйлдвэрлэгчийн серийн дугаар;
- (4) түрээсийн эхлэх болон дуусах хугацаа;
- (5) түрээсийн хэлбэр;
- (6) нислэгийн төрөл, үйл ажиллагааны цар хүрээ.

(d) Монгол Улсад ашиглагдаж байгаа Нислэгт тэнцэх чадвар (цаашид “НТЧ” гэх)-ын гэрчилгээ нь хүчингүй болсон түрээсийн агаарын хөлгийг зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэрт нислэгт шалгах, эсхүл түүний байршил солигдох шаардлагатай тохиолдолд Даргаас ИНД-21 Бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлэлт (цаашид “ИНД-21” гэх)-ийн дагуу олгосон тусгай нислэгийн зөвшөөрлийн үндсэн дээр нислэг үйлдэж болно.

(e) Энэ зүйлийн (d)-д заасан тохиолдол гадаад улсад тохиолдвол тухайн агаарын хөлгийг бүртгэгч улсын иргэний нисэхийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай нислэгийн зөвшөөрлийн үндсэн дээр

нислэг үйлдэж болно.

(f) Түрээсийн хугацаанд түрээсийн агаарын хөлгийн нислэгийн бүх төрлийн үйл ажиллагаа нь холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан баримт бичгийн дагуу явагдаж байгаа эсэхэд Дарга хяналт тавина.

(g) Түрээсийн агаарын хөлгийн Нислэгт зөвшөөрөгдөх минимум төхөөрөмжийн жагсаалт (цаашид “MEL” гэх)-ыг Дарга баталж, эсхүл хүлээн зөвшөөрч болно.

131.13. Түрээсийн гэрээнд тавигдах шаардлага

(a) Түрээсийн зөвшөөрөл олгогдсон агаарын тээвэрлэгч нь түрээсийн гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 7 хоногийн дотор түрээсийн гэрээний хүчин төгөлдөр хувийг Даргад хүргүүлнэ.

(b) Агаарын тээвэрлэгч түрээсийн гэрээ болон гэрээний нэмэлт өөрчлөлтийн хүчин төгөлдөр хувийг тухайн гэрээний дагуу сүүлчийн нислэг үйлдсэн өдрөөс хойш нэгээс доошгүй жилийн хугацаанд хадгална.

(c) Түрээсийн гэрээнд агаарын хөлгийн НТЧ-ын стандартад хамаарах асуудлаар дараах мэдээллүүд тодорхой тусгагдсан байна:

(1) түрээслэгч болон түрээслүүлэгч талууд тодорхой заагдсан байх;

(2) түрээсийн агаарын хөлгийн маяг, хийц, бүртгэлийн дугаар, үйлдвэрлэлийн дугаар;

(3) түрээсийн хугацаа;

(4) түрээсийн агаарын хөлгийн ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих этгээд;

(5) агаарын хөлөг аль улсын бүртгэлд байх;

(6) агаарын хөлөгт гүйцэтгэгдэх техник үйлчилгээнд хүлээх үүрэг хариуцлага;

(7) түрээсийн агаарын хөлөгт ашиглах техник үйлчилгээний хөтөлбөр;

(8) түрээсийн агаарын хөлөг нь бүртгэгч улсын НТЧ-ын шаардлагыг хангаж байгаа болон агаарын тээвэрлэгчийн үйл ажиллагааны заавар, журмын дагуу үйл ажиллагаанд оролцох талаар.

131.14. Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 83 bis дугаар зүйл

(a) Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц (цаашид “Конвенц” гэх)-ын 83 bis дугаар зүйлийн дагуу агаарын хөлгийг бүртгэгч улс нь өөрийн хүлээсэн хяналтын үүрэг, хариуцлагаас заримыг буюу бүгдийг нь тухайн агаарын хөлгийг түрээсээр авч ашиглаж байгаа агаарын тээвэрлэгчийг харьяалах улсад шилжүүлж болно.

(b) Түрээсийн гэрээнд оролцогч тал нь Конвенцын хэлэлцэн тохирогч улс бол, Дарга Конвенцын 83 bis дугаар зүйлийн дагуу Конвенцын 12, 30, 31 болон 32(a) зүйлүүдэд заагдсан үүрэг, хариуцлагаас шилжүүлэх тухай Харилцан ойлголцох гэрээг тухайн агаарын хөлгийг бүртгэгч улстай байгуулж болно.

(c) Дарга, Монгол Улс нь Конвенцын 83 bis дугаар зүйлд заасан гэрээний дагуу гадаад улсын эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсан тухай Иргэний нисэхийн олон улсын байгууллагад болон агаарын тээвэрлэгчид мэдээлнэ.

(d) Агаарын тээвэрлэгч нь энэ зүйлийн (b)-д заасны дагуу байгуулсан гэрээний баталгаажсан хуулбар, эсхүл гэрээний хураангуйг түрээсийн агаарын хөлөгт байнга авч явна.

131.15.Түрээсийн үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага

(a) Аливаа этгээд агаарын хөлөг түрээслэхдээ дараах шаардлагыг хангасан болохоо Даргад бататгана:

(1) түрээслэгч, түрээслүүлэгч талууд, эсхүл зөвхөн түрээслэгч нь түрээсийн гэрээний хугацаанд хүчин төгөлдөр Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч байна;

(2) түрээслэгч нь техник үйлчилгээний хөтөлбөр болон техник үйлчилгээний хяналтын системтэй байна;

(3) агаарын хөлгийн хууль ёсны эзэмшигч нь дараах мэдээллийг бичгээр ирүүлсэн байна:

(i) агаарын хөлгийн маяг, улсын бүртгэлийн дугаар, үйлдвэрлэгчийн серийн дугаар;

(ii) агаарын хөлгийг эзэмшигч, эсхүл өмчлөгч, эсхүл түрээслэгчийн нэр, хаяг, утас;

(iii) агаарын хөлгийг түрээслэх талаар эзэмшигч, эсхүл өмчлөгчийн зөвшөөрөл;

(iv) түрээсийн эхлэх болон дуусах хугацаа;

(v) түрээсийн хугацаанд агаарын хөлгийн техник үйлчилгээг хариуцах этгээдийн нэр;

(vi) агаарын хөлөгт техник үйлчилгээ хийх байгууллагын хаяг, техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээний дугаар.

(b) Түрээсийн агаарын хөлгийн ашиглалттай холбоотойгоор Дарга дараах мэдээллийг агаарын тээвэрлэгчээс шаардана:

(1) түрээсийн агаарын хөлгөөр нислэг үйлдэх нисэх багийн гишүүд эрх бүхий байгууллагаас олгогдсон мэргэжлийн үнэмлэхтэй байх;

(2) түрээсийн агаарын хөлгийн даатгалын холбогдолтой мэдээлэл.

(с) Эзэмшигч, өмчлөгчийн зөвшөөрөлгүй түрээсийн агаарын хөлгийг дамжуулан түрээслэхийг хориглоно.

131.17. Түрээсийн зөвшөөрлийг хүчингүй болгох

(а) Дарга дараах тохиолдолд энэ дүрмийн 131.11-ийн дагуу олгогдсон зөвшөөрлийг хүчингүй болгоно:

(1) түрээсийн гэрээ цуцлагдсан, эсхүл;

(2) түрээсийн гэрээний хугацаа дууссан, эсхүл;

(3) агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ хүчингүй болсон, эсвэл энэ талаар Даргад мэдээлээгүй, эсхүл;

(4) агаарын хөлгийн эзэмшигч, өмчлөгч өөрчлөгдсөн талаар Даргад мэдээлээгүй, эсхүл;

(5) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, түдгэлзсэн, эсхүл хүчингүй болсон.

131.18. Түрээсийн гэрээг сунгах

(а) Түрээсийн гэрээний хугацааг сунгахаар төлөвлөж буй агаарын тээвэрлэгч нь гэрээнд орох нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болохоос 14 хоногийн өмнө Даргад бичгээр мэдэгдэх бөгөөд дараах мэдээллийг ирүүлсэн байна:

(1) түрээсийн хугацаанд гарсан нислэгийн саатлын тайлан;

(2) түрээсийн хугацаанд нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтыг хангахтай холбогдолтой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан;

(3) түрээсийн агаарын хөлгийн НТЧ-ын хадгалалт.

131.19. Түрээсийн агаарын хөлөг

(а) Гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгийг түрээслэх тохиолдолд, агаарын хөлгийг түрээсийн хугацаанд түрээслэгч улсад бүртгүүлэхээр гэрээнд заасан бол, түрээслэгч нь агаарын хөлгийг түрээслүүлэгч улсын бүртгэлээс хасуулж, ИНД-47 Агаарын хөлгийн бүртгэл (цаашид “ИНД-47” гэх)-ийн дагуу Монгол Улсын бүртгэлд бүртгүүлнэ.

(б) Дарга, түрээслүүлэгч улстай энэ дүрмийн 131.14-ийн (б)-д заасны дагуу Харилцан ойлголцох гэрээ байгуулаагүй тохиолдолд, түрээслүүлэгч улсын хүсэлтийн дагуу түрээсийн агаарын хөлөгт НТЧ-ын үзлэг шалгалт хийж болно.

(с) Түрээсийн гэрээний хугацаанд, түрээсийн зөвшөөрлийн нөхцөлд хамаарах аливаа зөрчил, дутагдлын талаар түрээслэгч болон түрээслүүлэгч улсад харилцан мэдээлнэ.

(д) Түрээслэгч болон түрээслүүлэгч улсын иргэний нисэхийн эрх бүхий байгууллагууд түрээсийн агаарын хөлөгт хамаарах аливаа техникийн болон үйл ажиллагааны стандарт, шаардлагын талаарх мэдээллийг харилцан солилцох ба түрээсийн үйл ажиллагаатай

хамааралтай байгуулсан гэрээ, хэлцлийн нөхцөлд нөлөөлөхүйц аливаа өөрчлөлтийн талаар харилцан зөвшилцсон байна.

(е) Түрээслэгч болон түрээслүүлэгч улсын иргэний нисэхийн эрх бүхий байгууллагаас түрээсийн агаарын хөлөгт тавьж байгаа шаардлагууд зөрчигдвөл аль талын стандарт, шаардлагыг мөрдүүлэх талаар талууд хамтарч тодорхойлно.

(f) Монгол Улсад түрээсээр ашиглах агаарын хөлгийн насжилт нь:

(1) Хэрэв гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгийг түрээсийн хугацаанд түрээслүүлэгч улсын бүртгэлээс хасуулж, Монгол Улсын бүртгэлд бүртгүүлэх тохиолдолд ИНД-47-ийн 47.55 (7)-ийн шаардлагыг хангасан байна; эсхүл

(2) ИНД-119 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт (цаашид ИНД-119 гэх)-ийн 119.153 (d)-д заасны дагуу нислэгийн үйл ажиллагааны шаардлагыг хангасан байна.

131.21. Түрээсийн агаарын хөлгийн техник үйлчилгээ

(а) Дарга, түрээсийн зөвшөөрөл олгохоос өмнө, мөн түрээсийн хугацаанд, тухайн агаарын хөлөг дээр хийгдсэн маягийн болон бүтцийн аливаа өөрчлөлтүүд нь түрээслүүлэгч талын эрх бүхий байгууллагаас зөвшөөрөгдсөн гэдгийг хянан бататгана.

(b) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт энэ дүрмийн 131.11-д заасан зөвшөөрөл олгогдсон тохиолдолд агаарын хөлгийг түрээслүүлэгч нь түрээслэгчид тухайн агаарын хөлөгт хамаарах НТЧ-ын бүх удирдамжийг хүргүүлсэн байна.

(c) Гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгийг түрээслэхээс өмнө түүнд хамаарах НТЧ-ын удирдамжийн хэрэгжилтийг түрээслэгч хянан бататгасан байна.

(d) Түрээслэгч болон түрээслүүлэгч талууд энэ дүрмийн 131.14-ийн (b)-д заасан Харилцан ойлголцох гэрээ байгуулаагүй тохиолдолд, түрээсийн агаарын хөлөг дээр хийгдэх техник үйлчилгээ нь түрээслүүлэгч улсын иргэний нисэхийн эрх бүхий байгууллагаас баталсан, эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу хийгдэж байгаад Дарга хяналт тавина.

*Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын
16-ны өдрийн А/283 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

ИНД - 138 Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа

А Бүлэг - Ерөнхий зүйл

138.1. Зорилго

(а) Энэ дүрмээр дараах харилцааг зохицуулна:

(1) эрэн хайх, авран туслах (цаашид “ЭХАТ” гэх) үйл ажиллагааны мэдээлэл зохицуулах төвийн үйл ажиллагаа;

(2) ажлын байранд тавигдах шаардлага;

(3) аюулын үе шат ба ажиллагаа.

138.3. Нэр томьёо ба товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэсэн нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

В Бүлэг – ЭХАТ үйл ажиллагааны зохион байгуулалт

138.51. Иргэний нисэхийн ЭХАТ үйл ажиллагааны бүс

(а) Иргэний нисэхийн ЭХАТ үйл ажиллагааны бүс нь Монгол Улсын Нислэгийн мэдээллийн бүс (цаашид “FIR” гэх)-ийн хэмжээнд байна.

(b) Дарга, иргэний нисэхийн ЭХАТ үйл ажиллагааны бүсийг Олон улсын иргэний нисэхийн байгууллага (цаашид “ICAO” гэх)-д мэдээлж, Ази Номхон далайн бүсийн агаарын навигацийн төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээг авсан байна.

138.53. ЭХАТ үйл ажиллагаа гүйцэтгэх байгууллага

(а) Аюул тулгарсан болон аюулд нэрвэгдсэн иргэний агаарын хөлөг, агаарын хөлгийн баг, зорчигчдыг ЭХАТ үйл ажиллагааг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, бусад холбогдох баримт бичгийг үндэслэн батлан хамгаалах, хил хамгаалах, хэв журам сахиулах болон эрүүл мэндийн байгууллага, мөн бусад шаардлагатай төрийн чиг үүргийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

(b) Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд аюул тулгарсан агаарын хөлгийн талаар холбогдох байгууллагад зохих журмын дагуу нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

(c) Улсын онцгой комисс, эсхүл онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зохих хууль тогтоомжийн дагуу холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч, аюул тулгарсан агаарын хөлгийг ЭХАТ үйл ажиллагааг эхлүүлэх хүртэл хугацаанд Агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын, ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төвөөс энэ зүйлийн (а)-д заасан байгууллагад

мэдээлэл дамжуулах арга хэмжээг авах үүрэгтэй.

138.55. ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв

(а) Иргэний нисэхийн ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь энэхүү дүрэмд нийцүүлэн холбогдох үйл ажиллагааг зохион байгуулна.

(b) энэ зүйлийн (а)-д заасан төв нь ЭХАТ үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байгаа болон гүйцэтгэж байгаа албан тушаалтан, байгууллага, нэгжид дэмжлэг үзүүлэхтэй холбоотой мэдээлэл зохицуулалтын үүргийг гүйцэтгэнэ.

(с) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь 24 цагаар байнгын үйл ажиллагаа явуулна.

(d) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь дараах баримт бичгийг боловсруулж, мөрдөнө:

(1) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төвийн үйл ажиллагааны заавар;

(2) ослын мэдээлэл хүлээн авах, дамжуулах журам;

(3) ЭХАТ үйл ажиллагаа явуулах хилийг тодорхойлох журам.

(е) ЭХАТ үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах үүднээс шаардлагатай гэж үзвэл ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах дэд төвүүдийг байгуулж болно.

(f) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь Агаарын хөлгийн ослын байршлыг тогтоох хиймэл дагуулд суурилсан байршил тогтоох систем (цаашид “COSPAS-SARSAT” гэх)-ээс мэдээлэл хүлээн авах цэг байна.

138.57. ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төвийн ажлын байранд тавигдах шаардлага

(а) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь дараах ажлын байр, төхөөрөмж, хэрэгслээр хангагдсан байна:

(1) ЭХАТ үйл ажиллагааны мэдээлэл зохицуулалтын ажлын байр;

(2) FIR, Нислэгийн хөдөлгөөний удирдлага (цаашид “НХУ” гэх)-ын бүс, секторын хуваарилалт, агаарын зайн бүтэц, зохион байгуулалт болон хариуцлагын бүсийн зураг;

(3) эрэн хайх бүсийг тодорхойлоход ашиглагдах програм хангамж, системүүд;

(4) штурманы тооцооны хэрэгсэл;

(5) радио холбооны хэрэгсэл;

(6) харилцаа холбооны хэрэгсэл;

(7) ЭХАТ үйл ажиллагаанд шаардлагатай бусад тоног төхөөрөмж, хэрэгсэл.

(b) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь радио холбооны дараах хэрэгсэлтэй байна:

(1) хэт богино долгионы 121.5 МГц давтамж дээр хүлээн авагч болон дамжуулагч;

(2) богино долгионы 5680 КГц давтамж дээр хүлээн авагч болон дамжуулагч;

(3) эрлийн бүсэд эрэн хайх үйл ажиллагаа явуулж байгаа бие бүрэлдэхүүн, нэгжтэй холбоо тогтоох хэт богино долгионы 123.1 МГц давтамж дээр хүлээн авагч болон дамжуулагч;

(4) Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (цаашид “НХҮ” гэх)-ний радио холбоог сонсох боломжтой радиостанц.

(c) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь харилцаа холбооны дараах хэрэгсэлтэй байна:

(1) улс хооронд ба хот хоорондын ярианы эрх бүхий телефон утас;

(2) Нисэхийн мэдээ зохицуулах систем (цаашид “AMHS” гэх);

(3) интернэт, эсхүл тохиромжтой бусад гарцууд.

138.59. ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төвийн ажилтанд тавигдах шаардлага

(a) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төвийн ажилтан нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) ЭХАТ үйл ажиллагааны мэдээлэл зохицуулах чадвартай, Даргаар хүлээн зөвшөөрөгдсөн сургалтыг төгссөн байх;

(2) радио холбоо, телефон утсан холбоогоор англи хэлээр харилцах болон радио холбооны загварчилсан хэллэгийн зохих мэдлэг, чадвартай байх.

(b) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь ажилтнуудын сургалт дадлагын бүртгэлийг хөтөлж, хадгална.

138.61. ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төвийн үйл ажиллагааны заавар

(a) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төвийн үйл ажиллагааны зааварт дараах зүйлсийг тусгасан байна:

(1) ЭХАТ үйл ажиллагааны зохион байгуулалтын ерөнхий бүдүүвч, ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төвийн гүйцэтгэх үүрэг;

(2) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төвийн удирдах ажилтан, ажилтан тус бүрийн үүрэг хариуцлага;

(3) удирдах ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;

(4) хэвийн болон аюулын нөхцөл байдлын үед ажилтнуудын гүйцэтгэх үүрэг;

(5) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах үйл ажиллагааны тайлан гаргах журам;

(6) эрэн хайх, аврах мэдээлэл зохицуулах төвийн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хадгалах сургалт, дадлагын хөтөлбөр.

138.63. ЭХАТ үйл ажиллагааны харилцан ажиллагааны зохицуулалт

(а) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь ЭХАТ үйл ажиллагааны мэдээлэл зохицуулах чиглэлээр дор дурдсан байгууллага, нэгжтэй харилцан ажиллагааны зохицуулалтын баримт бичигтэй байна. Үүнд:

(1) онцгой байдлын асуудал эрхэлсэн холбогдох байгууллага;

(2) агаарын тээвэрлэгч;

(3) хариуцлагын бүсэд байрлаж байгаа нисэх буудал, аэродромын үйл ажиллагаа эрхлэгч;

(4) батлан хамгаалах асуудал эрхэлсэн холбогдох байгууллага;

(5) эрүүл мэндийн асуудал эрхэлсэн холбогдох байгууллага;

(6) байгаль орчны асуудал эрхэлсэн холбогдох байгууллага;

(7) хил хамгаалах байгууллага;

(8) цагдаа, хэв журам сахиулах байгууллага;

(9) тухайн орон нутгийн захиргааны байгууллага;

(10) хүмүүнлэгийн байгууллага;

(11) харилцаа холбооны байгууллага;

(12) Даргын шаардлагатай гэж үзсэн бусад байгууллага.

(б) Энэ зүйлийн (а)-д заасан харилцан ажиллагааны зохицуулалтын баримт бичигт дараах зүйлсийг тусгана:

(1) харилцан ажиллагааны үндсэн зарчим;

(2) талуудын ЭХАТ үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, хариуцлага;

(3) талуудаас ЭХАТ үйл ажиллагаанд оролцох хүн хүч, техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн жагсаалт, ажиллах хуваарь;

(4) талуудын ЭХАТ үйл ажиллагааны хамрах хүрээ, хил хязгаар;

(5) үйл ажиллагаа явуулах хугацаа, тавигдах хязгаарлалтууд;

(6) талуудын хаяг, талууд хоорондын холбоо барих журам;

(7) талууд тус бүрийн ЭХАТ үйл ажиллагааг удирдах ажилтан;

(8) аюулын мэдээллийн пост, ослын талбайн захирагчийн томилолт;

(9) ЭХАТ хамтарсан буюу нэгдсэн дадлага сургалтад хамрагдах журам.

(с) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулалтын төв нь Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц (цаашид “Конвенц” гэх)-ын Хавсралтын стандарт зөвлөмж, ICAO-ын холбогдох баримт бичигт нийцүүлэн хөрш зэргэлдээх Улс болон Монгол Улсын Засгийн

газрын хооронд байгуулсан иргэний нисэхийн ЭХАТ үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах тухай болон бусад гэрээ хэлэлцээрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах үүрэгтэй.

138.65. Урьдчилсан бэлтгэл

(а) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь хүчин төгөлдөр дараах мэдээлэл бүхий лавлахтай байна:

(1) эрэн хайх, аврах үйл ажиллагааг гүйцэтгэх, түүнд оролцох байгууллага, нэгж, аюулын мэдээллийн постууд;

(2) Монгол Улсын FIR-д үйлчилгээ үзүүлж байгаа НХҮ-ний байгууллага;

(3) ЭХАТ үйл ажиллагаанд оролцох байгууллага нэгжийн хаяг, холбоо барих утас, бусад холбооны сувгууд;

(4) ЭХАТ үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх боломжтой радио станцын цэг, дуудлага, ажлын цагийн хуваарь;

(5) аврах хэрэгслийн хангалт, нөөц, тэдгээрийн агуулагдаж байгаа цэг, хаяг;

(6) хөрш зэргэлдээ улсын ЭХАТ байгууллагын хаяг, цагийн хуваарь;

(7) хоногийн нислэгийн төлөвлөгөө;

(8) Даргын шаардлагатай гэж үзсэн бусад холбогдох мэдээлэл.

138.67. ЭХАТ үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө

(а) ЭХАТ үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгана:

(1) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв, ЭХАТ үйл ажиллагааг гүйцэтгэх болон оролцох байгууллага, нэгж, тэдгээрийн үүрэг, хариуцлага;

(2) ЭХАТ үйл ажиллагааны удирдлага;

(3) ЭХАТ үйл ажиллагааг эхлүүлэх болон дуусгах журам;

(4) аюулын мэдээллийн постын ажиллах журам;

(5) аюулын тухай ба ЭХАТ үйл ажиллагаанд шаардлагатай нисэхийн болон бусад мэдээллийг хүлээн авах, дамжуулах журам;

(6) ЭХАТ үйл ажиллагааны үеийн ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төвийн үүрэг, хариуцлага;

(7) ЭХАТ үйл ажиллагаанд ашиглах харилцаа холбооны хэрэгсэл, давтамж, дуудлага, тэдгээрийг ашиглах аргачлал;

(8) ЭХАТ үйл ажиллагаанд ашиглах агаарын хөлөг, тээврийн хэрэгсэл, тэдгээрийг ашиглах аргачлал, шатахууны хангалт хийх цэг;

(9) ЭХАТ үйл ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмж, эд зүйлс, хүнс, аврах хэрэгслийн хангалт, нөөц, тэдгээрийн байршил;

(10) ослын талбар дахь үйл ажиллагаа;

(11) ослын талбар дахь үлдэгдлийг хамгаалах журам;

(12) ослын талбарын байршил дахь агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа дууссаны дараа нийгмийн аюулгүй байдлыг хангах үүднээс ослын талбарыг цэвэрлэх, ариутгах ажиллагаа.

(b) ЭХАТ үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө нь нисэх буудлын онцгой нөхцөлийн төлөвлөгөөтэй уялдсан байна.

138.69. ЭХАТ дадлага сургалт

(a) ЭХАТ үйл ажиллагааг үр дүнтэй явуулах бэлтгэлийг хангах зорилгоор ЭХАТ үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан байгууллага, нэгжийг хамарсан дадлага сургалт жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулагдсан байна.

138.71. Осол, зөрчлийн мэдээлэл дамжуулах

(a) Осол, зөрчлийн мэдээллийг ИНД-12 Осол, зөрчлийн мэдээлэл (цаашид “ИНД-12” гэх)-ийн дагуу мэдээлнэ.

138.73. Аюулын мэдээллийн пост

(a) Аюулын мэдээллийн пост нь аюул тулгарсан, эсхүл аюулд нэрвэгдсэн агаарын хөлгийн талаар мэдээлэл хүлээн авсан даруй холбогдох мэдээллийг ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төвд нэн даруй дамжуулна.

(b) Аюулын мэдээллийн пост гэж дараах этгээдийг ойлгоно:

- (1) агаарын хөлгийн баг;
- (2) НХҮ-ний байгууллага, түүний нэгжүүд;
- (3) нисэх буудал, аэродромын үйл ажиллагаа эрхлэгч;
- (4) хот суурин, орон нутгийн засаг захиргаа;
- (5) онцгой байдлын алба, түүний нэгжүүд;
- (6) цагдаагийн хэлтэс, тасаг;
- (7) батлан хамгаалах байгууллага;
- (8) хил хамгаалах байгууллагын анги салбар;
- (9) харилцаа холбооны байгууллага, салбарууд;
- (10) байгаль орчныг хамгаалах байгууллага, салбарууд;
- (11) цаг уурын ажиглалтын цэг, станц;
- (12) холбогдох аж ахуйн нэгж, байгууллага.

(c) Аюулын мэдээллийн пост нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төвд байнгын, шуурхай мэдээлэл дамжуулах харилцаа холбооны хэрэгсэлтэй;

(2) аюулын мэдээлэл болон ЭХАТ үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл дамжуулах бүдүүвчтэй;

(3) ЭХАТ үйл ажиллагаанд шаардагдах хүн хүч, техник хэрэгслийг дайчлан оролцуулах зохих эрх олгогдсон.

С Бүлэг - ЭХАТ үйл ажиллагаа

138.101. Мэдээллийг нягтлах, дүн шинжилгээ хийх

(а) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь зохих ЭХАТ үйл ажиллагааг эхлэхээс өмнө болон үйл ажиллагаа явагдаж байх хугацаанд, хүлээн авсан бүх мэдээлэл үнэн зөв, бодитой эсэхийг хянан баталгаажуулж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний яаравчлалын түвшин, үйлчлэх цар хүрээг тодорхойлох зорилгоор урьдчилсан дүн шинжилгээ хийнэ.

(b) Мэдээлэлд хийх шалгалт, дүн шинжилгээг аюулын нөхцөл байдлаас хамааран аль болох шуурхай гүйцэтгэж, холбогдох арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлнэ.

138.103. Аюулын үе шат ба ажиллагаа

(а) Аюулын үе шатуудыг дараах байгууллагууд зарлана:

(1) Тодорхойгүй үе (цаашид “INCERFA” гэх)-ийг НХҮ-ний байгууллага;

(2) Түгшүүрийн үе (цаашид “ALERFA” гэх), Аюулын үе (цаашид “DETRESFA” гэх)-ийг ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв.

138.105. НХҮ-ний мэдээлэл

(а) НХҮ-ний байгууллага, түүний нэгж нь аюулын нөхцөл байдлын талаар хүлээж авсан мэдээллийг аюулын нөхцөл байдлаас хамаарч ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төвд дараах дэс дарааллын дагуу мэдээлнэ:

- (1) мэдээллийн эх сурвалж;
- (2) аюулын нөхцөл байдлын төрөл, шинж чанар;
- (3) нислэгийн төлөвлөгөөнөөс авсан чухал өгөгдөхүүнүүд;
- (4) агаарын хөлөгтэй хамгийн сүүлд холбоо барьсан салбар, нэгж, агаарын хөлөгтэй холбоо барьсан цаг, ашигласан радио давтамж;
- (5) агаарын хөлгийн байрлалын талаарх сүүлчийн мэдээ, мөн байршлыг ямар аргаар тодорхойлсон тухай;
- (6) хэрэв боломжтой бол, агаарын хөлгийн өнгө ба таних тэмдэг;
- (7) мэдээлэл дамжуулсан салбар, нэгжээс авсан арга хэмжээ;
- (8) нөхцөл байдлын талаарх бусад мэдээлэл.

138.107. Бусад байгууллага, нэгжийн мэдээлэл

(а) Агаарын хөлөгт илт аюул тулгарсныг харсан, эсхүл энэ тухай мэдээлэл авсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь 138.73(b)-д заасан аюулын мэдээллийн постод, эсхүл аюулын мэдээллийн постын үүрэг гүйцэтгэх боломжтой гэж үзсэн төрийн байгууллага, нэгжид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

(b) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь хүлээн авсан бүх мэдээллийг нэгтгэн дүгнэж, тулгарсан нөхцөл байдалд тохирох аюулын үеийг зарлана.

138.109. Аюулын үе шатуудад авч хэрэгжүүлэх арга хэмжээ

(а) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь аюулын үе шатууд зарлагдсан тохиолдолд дараах арга хэмжээг тухайн нөхцөлд тохируулан авч хэрэгжүүлнэ:

(1) Тодорхой бус үе (INCERFA)-д дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

(i) НХҮ-ний байгууллага, түүний хамаарах нэгжтэй харилцан ажиллаж, агаарын хөлөг тодорхойгүй нөхцөл байдалд орсон, агаарын хөлөгт аюул тулгарсан байж болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээллийг шуурхай цуглуулах, нягтлан шалгах;

(ii) агаарын хөлөгт тулгарсан аюул, үүссэн нөхцөл байдлын талаар мэдээлэл дамжуулах ерөнхий бүдүүвчийн дагуу холбогдох албан тушаалтанд мэдээлэх;

(iii) нислэгийн төлөвлөгөө байхгүй тохиолдолд тухайн агаарын хөлгийн нислэг үйлдэх агаарын зам, нисэн гарсан болон буух тооцоот цагийг тодруулахад тус болохуйц мэдээлэл олж авах оролдлого хийх;

(iv) НХҮ-ний холбогдох салбар, нэгжтэй хамтран ажиллаж агаарын хөлгийн байршил, эсхүл түүний нислэгийн маршрутыг тодорхойлох оролдлогыг хийх;

(v) холбооны боломжит бүх сувгаар агаарын хөлөгтэй холбоо тогтоох оролдлогыг хийх;

(vi) буулт үйлдэх бололцоотой аэродром болон бусад газраас (нисэн гарсан аэродромыг оролцуулан) уг агаарын хөлгийн талаар лавлах;

(vii) авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд агаарын хөлгийн байршлыг тодорхойлох, тодорхой бус үеийг төгсгөх, эсхүл түгшүүрийн үед шилжих;

(viii) авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тулгарсан нөхцөл байдлын талаар НХҮ-ний байгууллага, агаарын тээвэрлэгч, холбогдох бусад байгууллага, нэгжид цаг тухайд нь мэдээлэх.

(2) Түгшүүрийн үе (ALERFA)-д дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

(i) ЭХАТ байгууллага, нэгжид нэн даруй мэдэгдэж бэлэн байдалд шилжүүлэх арга хэмжээг авах;

(ii) шинэ мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дүн шинжилгээ хийх;

(iii) аюул тулгарсан буюу аюулд нэрвэгдсэн байж болзошгүй агаарын хөлгийн байрлалыг тодорхойлох оролдлогыг хийх, энэ талаар харилцан ажиллагч, эсхүл ЭХАТ үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх боломжтой холбогдох байгууллага, нэгжтэй шуурхай холбоо тогтоож харилцан ажиллах;

(iv) нислэгийн төлөвлөгөө, цаг агаарын байдал, газрын гадаргуугийн тогтоц, радио холбоо сааталд орох магадлал, агаарын хөлгийн байрлалын талаарх сүүлчийн мэдээлэл, хамгийн сүүлд холбоо барьсан цаг, нисэгчийн зэрэглэл, дадал зуршил зэрэгт нарийвчилсан дүн шинжилгээ хийх, уг асуудлаар шаардлагатай байгууллага, нэгжтэй хамтран ажиллах;

(v) агаарын хөлгийн шатахуун дуусах цагийг тооцоолох, цаг агаарын таагүй нөхцөл байдалд уг агаарын хөлгийн нислэг, техникийн шинж чанар хэрхэн өөрчлөгдөж болохыг судлах;

(vi) авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд агаарын хөлгийн байрлалыг тогтоох оролдлогыг хийх, түгшүүрийн үеийг төгсгөх, эсхүл аюулын үед шилжих;

(vii) авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тулгарсан нөхцөл байдлын талаар НХҮ-ний байгууллага, агаарын тээвэрлэгч, холбогдох бусад байгууллага, нэгжид цаг тухайд нь мэдээлэх.

(3) Аюулын үе (DETRESFA)-д дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

(i) ЭХАТ үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний дагуу ЭХАТ үйл ажиллагааг шуурхай эхлүүлэх талаар ЭХАТ байгууллага, нэгжид мэдээлэх;

(ii) хүлээн авч дүн шинжилгээ хийсэн мэдээлэлд тулгуурлан агаарын хөлгийн байрлалыг тодорхойлох үйл ажиллагааг гүйцэтгэх;

(iii) агаарын хөлөг эзэмшигчид үүссэн нөхцөл байдлын талаар шуурхай мэдээлж, холбогдох мэдээллээр хангаж ажиллах;

(iv) ондоо эх сурвалжаас мэдээлэл хүлээн авсан тохиолдолд холбогдох НХҮ-ний байгууллага, нэгжид шуурхай мэдэгдэх;

(v) ЭХАТ үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан, эсхүл түүнд тусгагдаагүй боловч ЭХАТ үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх боломжтой радио станцын цэг, холбогдох нэгжид агаарын хөлөгт аюул тулгарсан буюу аюулд нэрвэгдсэн байж болзошгүй нөхцөл байдлын талаар шуурхай мэдээлж, уг агаарын хөлөгтэй холбоо тогтоох оролдлого хийх, агаарын хөлөгт боломжит дэмжлэг тусалцааг үзүүлэх, түүнтэй холбоотой мэдээ мэдээллээр шуурхай хангах хүсэлтийг тавих;

(vi) ЭХАТ үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний дагуу эрэн хайх бүс, ЭХАТ үйл ажиллагааг явуулах аргачлалын талаар санал боловсруулж ЭХАТ үйл ажиллагааны удирдлага, холбогдох байгууллага, нэгжид мэдээлэх;

(vii) агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад шуурхай мэдээлэх;

(viii) агаарын хөлгийг бүртгэсэн улсад үүссэн нөхцөл байдал, холбогдох мэдээллийг хүргүүлэх талаар холбогдох байгууллагатай

харилцан ажиллах;

(ix) агаарын хөлөг Монгол Улсын агаарын зайгаас гарсан байж болзошгүй тохиолдолд хөрш зэргэлдээх улсын ЭХАТ байгууллагад үүссэн нөхцөл байдлын талаар мэдэгдэж, шаардлагатай дэмжлэгийг авах талаар харилцан ажиллах;

(x) агаарын хөлөг хөрш зэргэлдээх улсын агаарын зайд нэвтрэн орсон бөгөөд ЭХАТ үйл ажиллагаа явуулах үүргийг тухайн улсын ЭХАТ байгууллага өөртөө авах хүртэл эрэн хайх үйл ажиллагааг зохицуулах.

138.111. Мэдээллийг бүртгэж баримтжуулах

(a) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь агаарын хөлөг аюулд нэрвэгдсэн, эсхүл аюул тулгарсан тохиолдол бүрийг тухайн мэдээлэл ирсэн цаг хугацаагаар нь дараах байдлаар бүртгэнэ:

(1) мэдээлэл хүлээж авсан эх сурвалж, аюулын мэдээллийн пост;

(2) мэдээлэл хүлээн авсан огноо, цаг, минут;

(3) мэдээллийн агуулга;

(4) мэдээлэл өгсөн, хүлээн авсан байгууллага, нэгж, ажилтан.

(b) Аюулын мэдээлэлд холбоотой мэдээллийн эх хувь, баримт нотолгоо (гэрэл зураг, видео бичлэг, цахилгаан мэдээ, маягтууд, газрын зураг болон бусад баримтууд)-г аюулын мэдээнд хавсаргана.

(c) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төвийн ажилтан энэ зүйлийн (a) хэсэгт заасан бүртгэлийг САА24138/01 маягтад бүртгэнэ.

138.113. ЭХАТ үйл ажиллагааг түр, эсхүл бүр зогсоох

(a) ЭХАТ үйл ажиллагааг, тухайн ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтны шийдвэрээр зогсооно.

(b) ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь энэ зүйлийн (a)-д заасан ЭХАТ үйл ажиллагааг зогсоосон тухай оролцож байгаа байгууллага, алба, нэгжид мэдээлнэ.

(c) ЭХАТ үйл ажиллагааг зогсоосны дараа агаарын тээвэрлэгч эрлийг үргэлжлүүлж болно. Энэ тохиолдолд ЭХАТ ажиллагааны мэдээлэл зохицуулах төв нь агаарын тээвэрлэгчийг шаардлагатай мэдээлэл, тусламжаар дэмжиж ажиллана.

(d) Эрлийн ажиллагаа, түүний үр дүнгээс шалтгаалан ЭХАТ үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон бөгөөд хүлээн авсан нэмэлт мэдээллийг үндэслэн шаардлагатай гэж үзвэл эрэн хайх үйл ажиллагааны удирдлагаас эрлийн ажиллагааг сэргээн, үргэлжлүүлж болно.

138.115. ЭХАТ үйл ажиллагааны дохио, тэмдэг

(a) ЭХАТ үйл ажиллагааны дохио, тэмдгийг дараах байдлаар Конвенцын Хавсралт 12-ын “Нэмэлт”-д заасан зааврыг мөрдөж,

ашиглана:

(1) ЭХАТ агаарын хөлөг нь тухайн эрэн хайж буй агаарын хөлгийг газрын гадаргад илрүүлсэн үед ашиглах дохио;

(2) агаарын хөлгийн баг, эсхүл зорчигчдоос ЭХАТ агаарын хөлөгт газраас өгөх дохио, тэмдэг;

(3) ЭХАТ үйл ажиллагааг гүйцэтгэж буй этгээдийн ЭХАТ агаарын хөлөгт газраас өгөх дохио, тэмдэг;

(4) ЭХАТ агаарын хөлгийн агаараас өгөх дохио.

*Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын
16-ны өдрийн А/283 дугаар тушаалын гуравдугаар хавсралт*

ИНД - 144 Нисэхийн хангамжийн байгууллага, гэрчилгээжүүлэлт

А Бүлэг - Ерөнхий зүйл

144.1. Зорилго

(а) Энэ дүрмээр нисэхийн хангамжийн байгууллагын гэрчилгээжүүлэлт болон үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтооно.

144.3. Нэр томьёо ба товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэсэн нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

144.5. Гэрчилгээний шаардлага

(а) Аливаа этгээд нь энэ дүрмийн дагуу олгосон Нисэхийн хангамжийн байгууллага (цаашид “НХБ” гэх)-ын гэрчилгээний эрхийн хүрээ болон нөхцөлд заагаагүй нисэхийн хангамжийн үйлчилгээг үзүүлэхгүй.

144.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах

(а) НХБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 25144/01 маягыг бөглөж, дараах баримтын хамт Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч (цаашид “Дарга” гэх)-д хүргүүлнэ:

- (1) 144.61-д шаардсан НХБ-ын Ерөнхий заавар;
- (2) төлбөрийн баримт.

144.9. Гэрчилгээний ангилал

(а) НХБ-ын гэрчилгээг дараах ангиллаар олгоно:

- (1) S1- Агаарын хөлгийн эд анги ханган нийлүүлэх байгууллагын гэрчилгээ;
- (2) S2- Материал ханган нийлүүлэх байгууллагын гэрчилгээ;
- (3) S3- Агаарын хөлгийг газрын тосны бүтээгдэхүүн (бензин, түлш)-ээр хангах үйлчилгээний байгууллагын гэрчилгээ.

144.11. Гэрчилгээ олгох

(а) Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагчид энэ дүрмийн дагуу НХБ-ын гэрчилгээ олгоно:

- (1) хүсэлт гаргагч В Бүлгийн шаардлагыг хангасан;
- (2) 144.51(а)(1)(2)-т шаардсан удирдах ажилтнууд нь тохирох зөв хүн байх;
- (3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

144.13. Гэрчилгээний хугацаа

(а) НХБ-ын гэрчилгээг 3 жилээс ихгүй хугацаагаар олгож, эсхүл гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгаж болно.

(б) НХБ-ын гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дуусах, түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй хэвээр байна.

(с) НХБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон тохиолдолд гэрчилгээг Даргад нэн даруй хураалгана.

(д) Гэрчилгээг түдгэлзүүлэх шийдвэр гарсан тохиолдолд НХБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.

144.15. Гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах

(а) НХБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас хамгийн багадаа 60 хоногийн өмнө САА 25144/01 маягтыг бөглөж, төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлнэ.

144.17 Гэрчилгээ эзэмшигч үйл ажиллагаагаа зогсоох

(а) Гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаагаа зогсоох тохиолдолд үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн өдрөөс 30 хоногийн өмнө Даргад бичгээр мэдэгдэнэ.

144.19. Гадаад улсын хүсэлт гаргагч

(а) Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь гадаад улсын иргэн, хуулийн этгээд бөгөөд Дарга тухайн хүсэлт гаргагчийг НХБ-ын гэрчилгээ эзэмших шаардлагатай гэж үзвэл гэрчилгээжүүлэлтийн асуудлыг энэ дүрмийн дагуу шийдвэрлэнэ.

В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага

144.51. Ажилтанд тавигдах шаардлага

(а) НХБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах этгээдийг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:

(1) Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон дараах үүрэг, хариуцлага хүлээх удирдах ажилтан:

(i) энэ дүрэмд заагдсан үйл ажиллагааны шаардлага, стандартыг хангах зорилгоор байгууллагын зүгээс авч хэрэгжүүлэх бүх үйл ажиллагааг тухайн байгууллагын хэмжээнд санхүүжүүлэх, хэрэгжүүлэх бүрэн эрхтэй;

энэ дүрэмд заасан шаардлага, стандартыг хангаж байгааг хүсэлт гаргагчийн өмнөөс бүрэн хариуцах;

(2) Гүйцэтгэх захирлын өмнө дараах үүрэг хариуцлага хүлээсэн удирдах ажилтнууд:

(i) тухайн хүсэлт гаргагч байгууллага нь Ерөнхий заавраа дагаж мөрдөж байгааг бататгах;

(ii) нисэхийн бүтээгдэхүүнээр хангалт хийхийг зөвшөөрөх;

(iii) 144.59-д шаардсан чанарын менежментийн тогтолцооны

хэрэгжилтийг хангах;

(iv) үзлэг, шалгалт хийх;

(v) нисэхийн бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх баримтыг бүрдүүлэх ба тэдгээрийг илгээх;

(3) Ерөнхий зааварт заасан хангамжийн үйл ажиллагааг төлөвлөх, ажиллуулах, хяналт тавих, үзлэг шалгалт хийх, гэрчилгээжүүлэх хангалттай тооны ажилтан.

(b) Энэ зүйлийн (a)(1)(i)-т шаардсан удирдах ажилтан нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон чанарын менежментийн тогтолцоотой холбоотой ур чадвар, туршлагаа нотолсон байх үүрэгтэй.

(c) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

(1) ажилтны сургалтын болон ур чадварын үнэлгээ хийх журмыг тогтоох;

(2) ажилтны ур чадварыг хадгалах журмыг тогтоох;

(3) ажилтанд тухайн үйлчилгээг гүйцэтгэх эрхийн хүрээг тодорхойлсон нотлох баримтыг бичгээр олгох.

144. 53. Барилга байгууламж, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага

(a) НХБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа хангамжийн үйл ажиллагаанд тохирсон дараах барилга байгууламж, тоног төхөөрөмжтэй байна.

(1) өөрийн хангамжийн үйл ажиллагааг удирдах захиргааны байр;

(2) үзлэг шалгалт, туршилт явуулах байр, тоног төхөөрөмж;

(3) бүтээгдэхүүн хүлээн авах ба илгээх байр, тоног төхөөрөмж;

(4) бүтээгдэхүүн хадгалах байр, агуулах.

(b) Үйл ажиллагаа явуулах орчин нь тухайн үйл ажиллагааны онцлогт тохирсон үзлэг, шалгалт явуулах, хадгалалтад шаардлагатай тусгай нөхцөлөөр хангагдсан гэдгийг хүсэлт гаргагч бататгана.

144.55. Хяналтын журам

(a) НХБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хангамжийн үйл ажиллагааны хяналтын талаар дараах зүйлийг багтаасан журмыг боловсруулсан байна:

(1) холбогдох стандарт болон ашиглалтын шаардлагыг хангаж буйг тодорхойлох үүднээс нисэхийн бүтээгдэхүүнд үзлэг, шалгалт хийх журам;

(2) нисэхийн бүтээгдэхүүн бүрийн хувьд:

(i) тухайн бүтээгдэхүүний тодорхойлолтыг зөв тогтоох;

(ii) тухайн бүтээгдэхүүн нь энэ зүйлийн 2(i)-д заагдсан тодорхойлолтод нийцэж буйг бататгах журам.

(3) стандарт эд ангиудаас бусад нисэхийн бүтээгдэхүүн бүрийн

хувьд Даргын хүлээн зөвшөөрсөн стандартад нийцэж буйг тодорхойлох журам;

(4) нисэхийн бүтээгдэхүүн бүр нь:

(i) зөвшөөрөлтэй гэдгийг, эсхүл

(ii) энэ зүйлийн 2(i)-т заасан, үндсэн баримт бичигтэй гэдгийг бататгах журам;

(5) нисэхийн бүтээгдэхүүн бүрийг тээвэрлэлтийн нөхцөлийг хангаж илгээсэн гэдгийг бататгах журам;

(6) хадгалагдаж буй эд ангийг гэмтэх, муудахаас сэргийлэх журам;

(7) ханган нийлүүлэх үзлэг хийгдээгүй эд ангиудыг тусгаарлах журам;

(8) нислэгт тэнцэх чадвар (цаашид “НТЧ” гэх)-ын стандартад нийцээгүй эд ангиудыг тусгаарлах журам.

(б) Ханган нийлүүлэх бүтээгдэхүүн бүрийн хувьд дараах шаардлагыг хангасан байна:

(1) тухайн бүтээгдэхүүний төрөл, загварыг Даргаас хүлээн зөвшөөрсөн байна;

(2) бүртгэл, хяналтын дугаартай байна;

(3) хэрэв тухайн бүтээгдэхүүн нь өөр нисэхийн бүтээгдэхүүнийг орлуулахаар зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн бол түүнийг үйлдвэрлэгчээс гаргасан баталгааг хавсаргасан байна;

(4) дараах зүйлийг тусгасан байна:

(i) хангамжийн байгууллагын албан ёсны нэр, гэрчилгээний дугаар;

(ii) зөвшөөрөл олгогдсон он сар, өдөр;

(iii) бүтээгдэхүүний тодорхойлолт, үйлдвэрлэлийн болон серийн дугаар, хэрэв шаардлагатай бол техникийн зураг, онцлог тодорхойлолтууд;

(iv) тухайн бүтээгдэхүүний хадгалалтад байх болон ашиглалтаас хасагдах хугацаа зэргийг тусгасан ашиглалтын аливаа хязгаарлалтууд;

(v) тоо хэмжээ;

(vi) үйлдвэрлэлтийн явцад тухайн бүтээгдэхүүнд хийсэн аливаа өөрчлөлт, шинэчлэлтийн талаарх бичилтүүд;

(5) гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт тусгагдсан эрх бүхий этгээдээр баталгаажсан байна;

(6) эд ангид бэхэлж, тогтооход тохиромжтой хэлбэрээр үйлдэгдсэн байна.

144.57. Бүртгэл

(а) НХБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий зааварт

заасан нисэхийн бүтээгдэхүүнээр хангахад шаардлагатай бүртгэлийг таньж тогтоох, индексжүүлэх, цуглуулах, хадгалах, хөтлөх болон устгах журамтай байна.

(b) Хүсэлт гаргагч нь дараах бүртгэл, тэмдэглэлийг байнга хөтөлнө:

(1) ханган нийлүүлэх үйл ажиллагаанд оролцох ажилтнуудын туршлага, мэргэжил, сургалт болон тэдгээрт олгогдсон эрхийн тухай бүртгэл;

(2) бүтээгдэхүүнийг хадгалах байр, агуулахын үйл ажиллагаа горимын дагуу явагдаж буйг баталгаажуулсан бүртгэл;

(3) тухайн байгууллагын ханган нийлүүлэх бүх бүтээгдэхүүний бүртгэл;

(4) энэ дүрмийн 144.55(а)(3)-т заасан тодорхойлолт болон тухайн байгууллагаас гаргасан ханган нийлүүлэх зөвшөөрлийн бүртгэл;

(5) энэ зүйлээр шаардсан бүртгэл тэмдэглэлийг хөтөлсөн өдрөөс хойш 5 жилээс доошгүй хугацаагаар хадгална.

144.59. Чанарын менежментийн тогтолцоо

(a) НХБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь чанарын менежментийн тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагаандаа мөрддөг байх үүрэгтэй.

144.61. НХБ-ын Ерөнхий заавар

(a) НХБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журам болон тогтолцооны мэдээллийг багтаасан Ерөнхий зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

(1) Дараах шаардлагыг хангасан болохыг бататган, хүсэлт гаргагч байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:

(i) заавар нь байгууллагын зохион байгуулалтын бүтцийг тодорхойлох ба энэ дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулсан байх;

(ii) байгууллагын ажилтнууд Ерөнхий заавар, холбогдох бусад бүх журам, зааврыг байнга дагаж мөрддөг байх;

(2) 144.59-д шаардсан чанарын менежментийн тогтолцооны хувьд ISO 9000 цуврал чанар баталгаажуулалтын стандартаар шаардсан бүх баримт бичиг.

(3) 144.51(а)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтнуудын албан тушаал, нэр;

(4) 144.51(а)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтнуудын дараах үүрэг, хариуцлага:

(i) хариуцсан чиг үүргийн хүрээнд тухайн байгууллагын нэрийн өмнөөс Даргатай шууд харилцах асуудал;

(ii) чанарын менежментийн тогтолцооны хүрээнд хамаарах

үүрэг хариуцлага;

(5) 144.51(а)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;

(6) энэ зүйлийн (а)(7)(i)-д заасан тухайн байгууллагын ажилтнуудын бүтцийн дэлгэрэнгүй мэдээлэл;

(6А) байгууллагын хүрээнд чанарын менежментийн хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;

(7) гэрчилгээнд тусгагдсан хангамжийн үйлчилгээний жагсаалт;

(8) дараах мэдээлэл бүхий жагсаалт:

(i) хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа байршил болон тоног төхөөрөмжийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл;

(ii) энэ зүйлийн (7)(i)-д заасан байршил тус бүр дэх ажлын бүтэц зохион байгуулалтын тухай нарийвчилсан мэдээлэл;

(iii) хангамжийн үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбогдуулан бусад хүмүүст олгосон зөвшөөрлийн тухай нарийвчилсан мэдээлэл;

(iv) энэ зүйлийн (7)(i)-д заасан байршлын хүрээлэн буй орчны тухай дэлгэрэнгүй мэдээлэл;

(v) энэ дүрмийн 144.51(3)-т заасан ажилтнуудын ур чадвар;

(vi) энэ дүрмийн 144.51(3)-т заасан ажилтнуудын сургалт;

(vii) шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүн нийлүүлэх зөвшөөрлийн хувийг багтаасан, хангамжийн үйл ажиллагааны хяналт;

(viii) энэ дүрмийн 144.57(а)-д заасан тэмдэглэл, мэдээллийг таньж тогтоох, индексжүүлэх, цуглуулах, хадгалах, хөтлөх болон устгах;

(ix) энэ дүрмийн 144.57-ын (b)-д заасан бүртгэл, тэмдэглэлийг байнга хөтлөх.

(9) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам;

(10) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар Даргаар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага

144.101. Байнгын хэрэгжилт

(а) НХБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) энэ дүрмийн В Бүлгийн шаардлага болон стандартыг хангах;

(2) Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан бүх журам болон тогтолцоог дагаж мөрдөх;

(3) Ерөнхий зааврын хүчинтэй бүрэн хувийг ажлын байр бүрд тогтмол хадгалах;

(4) Ерөнхий зааврын холбогдох бүлгийг шаардлагатай ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиглах боломжтой байлгах;

(5) САА 25144/01 маягтад шаардсан үйлчилгээ эрхлэх хаяг, утасны дугаар, эсхүл цахим шуудангийн хаягийн аливаа өөрчлөлтийг тухайн өөрчлөлт орсон өдрөөс хойш 28 хоногийн дотор Даргад мэдэгдэх;

(6) энэ дүрмийн 144.51-144.57-д заасан шаардлага ба стандартыг хангах;

(7) нисэхийн бүтээгдэхүүн нь НТЧ-ын хамаарал бүхий аюулгүй байдлын шаардлагыг хангасан, ашиглахад тохиромжтой гэдгийг тодорхойлсон байна.

144.103. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт

(а) НХБ-ын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий заавартаа шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг цаг тухайд нь оруулах үүрэгтэй.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг энэ дүрмийн холбогдох шаардлагад нийцэж байгаа ба тухайн Ерөнхий зааварт заасан нэмэлт өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдөж байгааг бататгах үүрэгтэй.

(с) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсны дараа тухайн зааврын нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргад нэн даруй хүргүүлнэ.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхийн өмнө Даргын зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай:

(1) 144.51(а)(1)-д заасан Гүйцэтгэх захирлыг өөрчлөх;

(2) 144.51(а)(2)-д заасан удирдах ажилтныг өөрчлөх;

(3) 144.61(а)(7)(i)-д заасан үйл ажиллагаа явуулж буй байр, байршлаа өөрчлөх;

(4) чанарын менежментийн тогтолцоо (хэрэв тухайн өөрчлөлт нь нөлөө бүхий өөрчлөлт бол).

(е) Энэ зүйлийн (d)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл түүнийг хийсний дараа тухайн гэрчилгээ эзэмшигчийн зайлшгүй дагаж мөрдөх нөхцөлийг Дарга тогтоож болно.

(f) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (е)-ийн дагуу Даргын тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.

(g) Хэрэв энэ зүйлд заасан өөрчлөлт нь гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардаж байгаа бол, гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад нэн даруй хүргүүлнэ.

(h) Нисэхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор шаардлагатай гэж Даргын үзсэн нэмэлт өөрчлөлтийг зааварт тусгах үүрэгтэй.

Хавсралт А - S3 ангиллын гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага

А.1. Ерөнхий зүйл

(а) S3 ангиллын гэрчилгээг агаарын хөлгийг газрын тосны бүтээгдэхүүнээр хангах үйлчилгээг ямар нэг шат дамжлагагүйгээр шууд гүйцэтгэдэг байгууллагад олгох ба гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн шаардлагыг хангасан байна.

(b) S3 ангиллын гэрчилгээ эзэмшигч нь газрын тосны бүтээгдэхүүний агуулах, түгээх цэгийг аэродромын аюулгүйн бүсэд барьсан тохиолдолд Даргаас зөвшөөрөл авч баталгаажуулсан байна.

А.2. Агаарын хөлөгт ашиглах газрын тосны бүтээгдэхүүнд тавигдах шаардлага:

(а) S3 ангиллын гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлөгт дараах төрлийн газрын тосны бүтээгдэхүүнээр үйлчилнэ:

(1) авто бензин (агаарын хөлөгт ашиглахыг зөвшөөрсөн) - Авто бензин техникийн шаардлага (MNS0217)-ыг хангасан АИ-95, АИ-98 төрөл;

(2) агаарын хөлгийн бензин - Gasoline aviation (DEF STAN 91)-ыг хангасан Авгаз 100 LL төрөл;

(3) агаарын хөлгийн түлш - Тийрэлтэт хөдөлгүүрийн түлш. Техникийн шаардлага (MNS 5677)-ыг хангасан ТС-1 төрлийн, Хийн турбинт хөдөлгүүрт агаарын хөлгийн түлш. Техникийн шаардлага (MNS 6394)-ыг хангасан Жет А-1 төрөл.

А.3. Техник, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага

(а) S3 ангиллын гэрчилгээ эзэмшигчийн ашиглаж буй техник, тоног төхөөрөмж нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) агаарын хөлөгт ашиглах газрын тосны бүтээгдэхүүний агуулах нь “Нисэх буудал дахь агаарын хөлгийн шатахууны агуулах, гидрант системийн үйл ажиллагаанд болон шатахууны чанарын хяналтад тавих шаардлага” (MNS 6941)-ыг бүрэн хангасан байна.

(2) тусгай тоноглолтой сумлагч авто машин, авто цистерн, багаж, тоног төхөөрөмж болон хэмжих хэрэгсэл нь дараах стандартын шаардлагыг хангасан байна.

(i) Агаарын хөлгийн шатахууны чанарын хяналт ба сумалгаа хийх үйл ажиллагаанд тавих шаардлага (MNS 6594);

(ii) Газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх авто цистернийг шалгах арга хэрэгсэл (MNS 5310);

(iii) Авто тээврийн хэрэгслийн ангилал. Техникийн байдалд тавих ерөнхий шаардлага (MNS 4598);

(iv) Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага (MNS4978);

(v) Цилиндр хэвтээ, ган нөөцлөх сав. Шалгах арга хэрэгсэл (MNS 5309);

(vi) Босоо цилиндр, ган нөөцлөх сав. Шалгах арга хэрэгсэл (MNS3-126);

(vii) Ерөнхий зориулалтын хуваарьт хэмжүүр. 1-р хэсэг: Хэмжил зүйн ба техникийн шаардлага (MNS OIML R35);

(viii) Шингэний тоолуур. Шалгах арга хэрэгсэл (MNS 3.123);

(b) Газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, тооцоо, судалгаанд ашиглаж байгаа хэмжүүр, хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжүүд нь эрх бүхий байгууллагаар баталгаажсан байна.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь газрын тосны бүтээгдэхүүний агуулахын тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа, судалгааг жил бүр шинэчлэн хөтөлж, Даргад хүргүүлнэ.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь тоног төхөөрөмжүүдэд техник ашиглалтын паспорт хөтөлж, засвар үйлчилгээг батлагдсан төлөвлөгөөний дагуу тогтмол хийх ба насжилт, ашиглалтын хугацаа дууссан тоног төхөөрөмж ашиглахыг хориглоно.

A.4. Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналт, технологийн мөрдөлт

(a) Гэрчилгээ эзэмшигч нь газрын тосны бүтээгдэхүүний чанарт хяналт тавих лабораторитай байна.

(b) Газрын тосны бүтээгдэхүүний чанарын анхан шатны, хяналтын болон хадгалалтын бүрэн шинжилгээнүүдийг “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн технологи, үйл ажиллагааны аргачлал” (MNS 4633)-д заасан хугацаанд тогтмол хийнэ.

(c) Гэрчилгээ эзэмшигч ын анхан шатны хяналтын, хадгалалтын бүрэн шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторид тогтмол хийнэ.

(d) Газрын тосны бүтээгдэхүүний дээжийг “Газрын тосны бүтээгдэхүүн. Дээж авах арга” (MNS 0218)-ын дагуу авна.

(e) Удаан хугацаагаар хадгалсан газрын тосны бүтээгдэхүүнийг ашиглахын өмнө бүрэн шинжилгээнд хамруулж, итгэмжлэгдсэн лабораториор баталгаажуулсан байна.

A.5. Галын аюулгүй байдлын шаардлага

(a) Гэрчилгээ эзэмшигчийн агуулах болон сумлагч авто машин, авто цистерн нь галын аюулгүй байдлын ерөнхий шаардлагыг хангасан байна.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь агуулах болон сумлагч авто машин, авто цистерний хүчин чадал, багтаамжид тохирсон галын анхан шатны багаж хэрэгслээр хангагдсан байна.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь ажилтнуудад галын техникийн анхан шатны мэдлэг олгох, галын аюулгүй байдлын зааварчилга өгөх

сургалтын хөтөлбөртэй байна.

(d) Аэродром орчмын аюулгүйн бүсэд байгаа гэрчилгээ эзэмшигчийн агуулахын тоног төхөөрөмжүүд дээр галын аюултай орчин болохыг анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулсан байна.

(e) Гэрчилгээ эзэмшигч нь нийслэлийн болон орон нутгийн Онцгой байдлын газартай гэрээ байгуулсан байхаас гадна гал унтраах анги, хэсэгтэй холбоо барих бололцоо бүхий найдвартай ажиллагаатай холбооны хэрэгсэлтэй байна.

(f) Гэрчилгээ эзэмшигч нь агуулахын гал унтраах төлөвлөгөөг боловсруулж ажлын байрандаа байрлуулсан байна. Тухайн төлөвлөгөөнд ажилтан нэг бүрийн гүйцэтгэх үүргийг тодорхой заасан байна.

(g) Гэрчилгээ эзэмшигчийн агуулах нь “Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” (MNS 4244), “Газрын тосны бүтээгдэхүүний галын аюулгүй байдал” (MNS 5282), “Галын аюулаас хамгаалах. Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм” (MNS 5566)-ыг мөрдөнө.

A.6. Бусад шаардлага

(a) Гэрчилгээ эзэмшигчийн ажилтнууд нь мэргэжлийн чиглэлээр ажилласан дадлага туршлагатай байна.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь ажилтнуудын ажил мэргэжлийг дээшлүүлэх сургалтын батлагдсан төлөвлөгөөтэй байна.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар А/489

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гаалийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.7, 268¹ дугаар зүйлийн 268¹.1.1, 269¹ дүгээр зүйлийн 269¹.1.1, 270¹ дугаар зүйлийн 270¹.1.4, 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.1, 271¹.1.2 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 10/07 дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1."Гаалийн баталгаат агуулахын горим хэрэгжүүлэх журам"-ыг 1 дүгээр, "Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын горим хэрэгжүүлэх журам"-ыг 2 дугаар, "Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горим хэрэгжүүлэх журам"-ыг 3 дугаар, "Гаалийн баталгаат барилгын талбайн горим хэрэгжүүлэх журам"-ыг 4 дүгээр, "Татваргүй барааны дэлгүүрийн горим хэрэгжүүлэх журам"-ыг 5 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Энэ журмыг гаалийн харилцаанд оролцогчдод сурталчлан таниулах, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, бүрдүүлэлтийн газар (Б.Даваасүрэн), Хуулийн хэлтэс (Ч.Тамираа)-т үүрэг болгосугай.

3.Шинээр батлагдсан гаалийн бүрдүүлэлтийн горимын кодыг гаалийн мэдээллийн автоматжуулсан CAIS системд оруулахыг Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төв (Б.Ганзориг)-д даалгасугай.

4.Энэ тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг харьяа гаалийн газар, хороодын дарга нарт үүрэг болгосугай.

5.Тушаал батлагдсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны Журам батлах тухай А/276 дугаар тушаал, 2023 оны Журам батлах тухай А/680 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ

*Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын
27-ны өдрийн А/489 дугаартай тушаалын 1 дүгээр хавсралт*

**ГААЛИЙН БАТАЛГААТ АГУУЛАХЫН ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гаалийн баталгаат агуулахын горим /цаашид “горим” гэх/-ыг хэрэгжүүлэхэд Зөвшөөрлийн тухай хууль, Гаалийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг мөрдөнө.

1.2. Горим сонгох, гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах мэдээлэл бичиг баримтыг үндэслэн барааг горимд байршуулах, горим дуусгавар болгох, гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Зөвшөөрөл авсан Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсын Стандартчилал, хэмжилзүйн үндэсний зөвлөлөөс баталсан агуулахын стандартын шаардлага хангасан байр, барилга байгууламж, задгай талбайд гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагааг эрхлэн явуулна.

1.4. Хуулийн этгээд нь гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмших хүсэлт гаргахдаа Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3, Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлд заасан бичиг баримтыг бүрдүүлэн гаалийн удирдах төв байгууллагад цахимаар ирүүлнэ.

1.5. Гаалийн удирдах төв байгууллага Гаалийн тухай хуулийн 138 дугаар зүйлийн 138.1.1-т заасны дагуу үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тохиолдолд Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн хяналт, тавьж ажиллах гаалийн байгууллага, гаалийн баталгаат агуулахын кодыг гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар батална.

1.6. Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрөлд заасан байршил, төрөл, зориулалт, талбайн хэмжээг өөрчлөхдөө шинэ талбайн хэмжээ, байрлал, барилга байгууламжийн зургийг холбогдох бусад материалын хамт бүрдүүлж, цахимаар хүсэлт гаргана. Энэ тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын гаалийн хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгж хүсэлтийг хүлээн авч хянаж, гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаал гаргаж шийдвэрлүүлнэ.

1.7. Хяналт тавих гаалийн байгууллага нь гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигчтэй горимын

нөхцөл, шаардлагыг хангуулах зорилгоор гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

1.8.Гаалийн баталгаат агуулахад бараа оруулж, гаргах хаалганы дээд талд тэгш өнцөгт хэлбэртэй 1.0х0.60 метрийн харьцаатай, цагаан дэвсгэртэй самбар дээр хар хөх өнгөөр “Гаалийн баталгаат агуулах” гэсэн бичээстэй, зүүн дээд өнцөгт Монгол Улсын гаалийн байгууллагын бэлгэ тэмдэг бүхий олон нийтэд мэдэгдэхүйц таних тэмдэг байрлуулна.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1.Горимд Гаалийн тухай хуулийн 142 дугаар зүйлд заасан барааг байршуулна.

2.2.Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

д	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг гаалийн баталгаат агуулахад оруулах.	700	шаардахгүй
2	Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг гаалийн баталгаат агуулахад оруулах.	701	шаардахгүй
3	Хилийн чанадад бүрмөсөн гаргасан монголын барааг гаалийн баталгаат агуулахад оруулах.	702	100, 101, 110, 120, 131 - 134
4	Барааг гаалийн баталгаат бүсээс гаалийн баталгаат агуулахад оруулах:		
	-гаалийн баталгаат агуулахаас	703	700, 703
	-гаалийн тусгай бүсээс	704	750 - 753, 758 - 765
	-татваргүй барааны дэлгүүрээс	705	740-747
5	Барааг чөлөөт бүсээс гаалийн баталгаат агуулахад оруулах.	706	770 - 771, 774 - 778
6	Гаалийн бусад хяналтад байгаа барааг гаалийн баталгаат агуулахад оруулах.	707	шаардахгүй
7	Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг гаалийн баталгаат агуулахад оруулах.	708	910, 911
8	Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газраас гаалийн баталгаат агуулахад оруулах.	709	720, 722 - 725

2.3.Гаалийн бүрдүүлэлтийн 703 - 707 болон 709 горимд гадаадын барааг байршуулна.

2.4.Гаалийн баталгаат агуулахаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах 451 горимд байршуулах согтууруулах ундаа, тамхинд онцгой албан татварын тэмдэг наах үйл ажиллагаанд хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч бүрэн хяналт тавьж ажиллана.

2.5.Бараа агуулахад байх хугацаанд гэмтсэн, муудсан, чанарын шаардлага хангахгүй болсон бол мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлт гаргуулж, гаалийн хууль тогтоомжийн дагуу гаалийн бүрдүүлэлт хийлгэнэ.

2.6.Барааг гаалийн баталгаат бүс, чөлөөт бүсээс энэ горимд байршуулахад өмнөх горимд байршсан хугацааг Гаалийн тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.1-д заасан хугацаанаас хасаж тооцно.

2.7.Энэ журмын 2.6-д заасны дагуу тооцож үзэхэд гаалийн баталгаат бүс, чөлөөт бүсэд байршуулсан нийт хугацаа нь Гаалийн тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.1-д заасан хугацаанаас хэтэрсэн тохиолдолд барааг энэ горимд байршуулахгүй.

2.8.Барааг горимд байршуулах хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө хугацаа сунгуулах хүсэлтийг гаалийн удирдах төв байгууллагын гаалийн хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгжид мэдүүлэгч эсхүл холбогдох этгээд гаргана.

2.9.Худалдах, худалдан авах гэрээ, төлбөрийн баримт болон бусад бичиг баримтыг үндэслэн гаалийн баталгаат агуулахад байх хугацаанд барааны өмчлөх эрхийг шилжүүлж болно. Өмчлөх эрхийг шилжүүлсэн барааг өөр горимд байршуулах гаалийн бүрдүүлэлт хийлгэхдээ мэдүүлгийн Илгээгч/Экспортлогч хүснэгтэд бараа өмчлөх эрхийг шилжүүлж байгаа хуулийн этгээд, иргэний нэр, Хүлээн авагч/Импортлогч хүснэгтэд өмчлөх эрх олж авч байгаа хуулийн этгээд, иргэний нэрийг бичнэ.

2.10.Гаалийн баталгаат агуулах эзэмшигч нь барааны бүртгэлийг оруулсан, гаргасан бараагаар хөтөлж, барааны хөдөлгөөний мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 03-ны өдрийн дотор хяналт тавьж ажилладаг гаалийн байгууллагад өгнө.

Гурав.Гаалийн баталгаат агуулахад хяналт тавих

3.1.Гаалийн баталгаат агуулахад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн ажил үйлчилгээ нь гаалийн хяналтад байна.

3.2.Гаалийн баталгаат бүс болон чөлөөт бүс хооронд барааг гаалийн итгэмжлэл авсан тээвэрлэгч тээвэрлэнэ.

3.3.Барааг гаалийн баталгаат бүс болон чөлөөт бүсээс өөр гаалийн байгууллагын хяналтад байгаа гаалийн баталгаат бүс болон чөлөөт бүс рүү шилжүүлэх тохиолдолд эхний гаалийн байгууллага гаалийн бүрдүүлэлтийг хийж, гаалийн мэдүүлгийг эцсийн бүрдүүлэлт хийх гаалийн байгууллагад гаалийн мэдээллийн автоматжуулсан системээр илгээж, барааг гаалийн хяналтад тээвэрлүүлнэ.

3.4.Гаалийн баталгаат агуулахад оруулах бараа нь өөр гаалийн байгууллагын хяналтад байгаа тохиолдолд дараах байдлаар гаалийн бүрдүүлэлтийг хийж, гаалийн итгэмжлэл бүхий тээврийн хэрэгслээр

тээвэрлүүлэн гаалийн хяналтад илгээнэ:

3.4.1.импортын манифесттай барааг гаалийн байгууллага хооронд бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэхдээ хаяг солих хүсэлтийг тээвэрлэгч тээврийн хэрэгслийн төрөл солигдох эсэхээс үл хамааран гаалийн удирдах төв байгууллагын хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгжид гаргаж шийдвэрлүүлэх;

3.4.2.гаалийн баталгаат бүсийн горимд байршуулсан барааг тухайн гаалийн байгууллагад мэдүүлж, гаалийн мэдүүлгийн “хүрэх газар” талбарт барааг оруулах гаалийн баталгаат агуулахын кодыг нөхөн бичих.

Дөрөв. Гаалийн болон бусад татвар

4.1.Гаалийн баталгаат агуулахын горимд байршуулах болон гаалийн баталгаат агуулахаас гаргах барааны татвартай холбогдох асуудлыг Гаалийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.2-137.5, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

4.2.Баталгаат агуулахын горимд байршуулсан бараанд дараах тохиолдолд холбогдох гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ:

4.2.1.давагдашгүй хүчин зүйлээс бусад шалтгаанаар гаалийн баталгаат агуулахаас алдагдсан, устгагдсан;

4.2.2.энэ журмын 4.2.1-д зааснаас өөр бусад хэлбэрээр гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй захиран зарцуулсан.

4.3.Энэ журмын 4.2-т заасан тохиолдолд импортын татварыг зөрчил илрүүлсэн өдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, гаалийн тарифаар ногдуулан, хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ.

Тав. Бусад

5.1.Гаалийн баталгаат агуулахын горимд байршуулах хугацаа хэтэрсэн барааг Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

5.2.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тохиолдолд тухайн гаалийн баталгаат агуулахад байршиж буй барааг Гаалийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2-т заасан хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд шилжүүлнэ.

5.3.Энэ журмын 5.2-т заасан хугацаанд барааг гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулаагүй тохиолдолд Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

5.4.Гаалийн байгууллага нь гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний үндсэн

дээр барьцааны болон улсын орлогын барааг гаалийн баталгаат агуулахад хадгалуулж болно.

5.5.Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан, хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн тохиолдолд үлдэгдэл барааг тоолж, гаалийн баталгаат агуулах ажиллуулж байсан байр, агуулахад гаалийн хяналтад хадгална. Энэ тохиолдолд барааг түр агуулахад байгаад тооцох ба түр агуулахад хадгалах хугацаа дуусгавар болохоос өмнө гаалийн хууль тогтоомжийн дагуу холбогдох горимд шилжүүлнэ.

Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 27-ны
өдрийн А/489 дугаартай тушаалын 1 дүгээр хавсралтаар
батлагдсан журмын хавсралт

ГААЛИЙН БАТАЛГААТ АГУУЛАХАД ХАДГАЛАГДАЖ БАЙГАА
БАРААНЫ ШОШГО

Д	Бараа эзэмшигч	Барааны нэр	Гаалийн баталгаат агуулах						Үлдэгдэл тоо хэмжээ
			оруулсан			гаргасан			
			огноо	гаалийн мэдүүлгийн дугаар	тоо хэмжээ	огноо	гаалийн мэдүүлгийн дугаар	тоо хэмжээ	
1.									
2.									
3.									

*Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын
27-ны өдрийн А/489 дугаартай тушаалын 2 дугаар хавсралт*

ГААЛИЙН БАТАЛГААТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын горим /цаашид “горим” гэх/-ыг хэрэгжүүлэхэд Зөвшөөрлийн тухай хууль, Гаалийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг мөрдөнө.

1.2. Горим сонгох, гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг үндэслэн барааг горимд байршуулах, горим дуусгавар болгох, гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт дараахь үйл ажиллагаа явуулна:

1.3.1. бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

1.3.2. материал, түүхий эдийг боловсруулах;

1.3.3. засвар, үйлчилгээ хийх;

1.3.4. барааны дээж, сорьц, загвар авах.

1.4. Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагааг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд холбогдох зөвшөөрлийн дагуу эрхлэн явуулна.

1.5. Хуулийн этгээд нь гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3, Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлд заасан бичиг баримтыг бүрдүүлэн гаалийн удирдах төв байгууллагад цахимаар ирүүлнэ.

1.6. Гаалийн удирдах төв байгууллага Гаалийн тухай хуулийн 138 дугаар зүйлийн 138.1.2-т заасны дагуу үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тохиолдолд Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн хяналт, тавьж ажиллах гаалийн байгууллага, гаалийн баталгаат үйлдвэрийн газрын кодыг гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар батална.

1.7. Хяналт тавих гаалийн байгууллага нь гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжтэй горимын нөхцөл, шаардлагыг хангуулах зорилгоор гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

1.8. Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт бараа оруулж, гаргах хаалганы дээд талд тэгш өнцөгт хэлбэртэй 1.0х0.60 метрийн

харьцаатай, цагаан дэвсгэртэй самбар дээр хар хөх өнгөөр “Гаалийн баталгаат үйлдвэрийн газар” гэсэн бичээстэй, зүүн дээд өнцөгт Монгол Улсын гаалийн байгууллагын бэлгэ тэмдэг бүхий олон нийтэд мэдэгдэхүйц таних тэмдэг байрлуулна.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1.Горимд үйлдвэрлэл явуулахад шаардагдах үндсэн болон туслах материалыг байршуулна.

2.2.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйлдвэрлэл явуулахад шаардагдах техник, тоног төхөөрөмжийг энэ горимд байршуулахгүй бөгөөд мэдүүлэгчийн сонгосон бусад горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

2.3.Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

Д	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг гаалийн баталгаат үйлдвэрийн газарт оруулах	710	шаардахгүй
2	Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг гаалийн баталгаат үйлдвэрийн газарт оруулах	711	шаардахгүй
3	Барааг гаалийн баталгаат бүсээс гаалийн баталгаат үйлдвэрийн газарт оруулах:		
	- гаалийн баталгаат агуулахаас	712	700, 703, 704, 706, 707, 709
	-гаалийн баталгаат үйлдвэрийн газраас	713	710, 712, 714, 715
	-гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газраас	716	720-725
	-гаалийн тусгай бүсээс	714	750-753, 758-765
4	Барааг чөлөөт бүсээс гаалийн баталгаат үйлдвэрийн газарт оруулах	715	770, 771, 774-778

2.4.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрууд нь нэг эзэмшигчтэй бөгөөд гаалийн баталгаат үйлдвэрийн газарт оруулсан, эсхүл тэнд үйлдвэрлэсэн барааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн өөр гаалийн баталгаат үйлдвэрийн газарт оруулахад гаалийн бүрдүүлэлтийн горимын 713 кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ.

2.5.Бараа гаалийн баталгаат үйлдвэрийн газарт байх хугацаанд гэмтсэн, муудсан, чанарын шаардлага хангахгүй болсон бол уг бараанд мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлт гаргуулж, гаалийн хууль тогтоомжийн дагуу гаалийн бүрдүүлэлт хийлгэнэ.

2.6.Барааг гаалийн баталгаат бүс, чөлөөт бүсээс энэ горимд байршуулахад өмнөх горимд байршуулсан хугацааг Гаалийн тухай

хуулийн 154 дүгээр зүйлийн 154.1-д заасан хугацаанаас хасаж тооцно.

2.7.Энэ журмын 2.6-д заасны дагуу тооцож үзэхэд гаалийн баталгаат бүс, чөлөөт бүсэд байршуулсан нийт хугацаа нь Гаалийн тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 154.1-д заасан хугацаанаас хэтэрсэн тохиолдолд барааг энэ горимд байршуулахгүй.

2.8.Барааг горимд байршуулах хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө хугацаа сунгуулах хүсэлтийг гаалийн удирдах төв байгууллагын гаалийн хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгжид мэдүүлэгч эсхүл холбогдох этгээд гаргана.

2.9.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын барааны орц, нормын тооцоо болон мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 03-ны өдрийн дотор хяналт тавьж ажилладаг гаалийн байгууллагад өгнө.

Гурав. Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт хяналт тавих

3.1.Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн ажил үйлчилгээ нь гаалийн хяналтад байна.

3.2.Горимд байршуулах бараанд гаалийн бүрдүүлэлт хийлгэхэд Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасан бичиг баримтаас гадна дараах бичиг баримтыг гаргаж өгнө:

3.2.1.үйлдвэрлэх бүтээгдэхүүн нь зах зээлд өрсөлдөх чадвартай болохыг нотолсон эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

3.2.2.технологийн бичиг баримт, түүнчлэн загвар, бараа тус бүрийн орц, материалын тооцоо;

3.2.3.шаардлагатай бусад бичиг баримт.

3.3.Журмын 3.2 дахь хэсэгт заасан мэдээлэл, бичиг баримт нь горимын шаардлага хангахгүй бол гаалийн байгууллага мэдүүлэгчээс нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.4.Мэдүүлэгч нь барааг гаалийн баталгаат үйлдвэрийн газарт боловсруулахтай холбогдуулан гаалийн байгууллагыг боловсруулах барааны нэр, материалын орцын тооцоо, хаягдал болон үлдэгдэл барааны хэмжээ, боловсруулалтын үр дүнд бий болох бүтээгдэхүүний загвар дээж, фото зураг, бүдүүвч зураг, худалдааны болон техникийн бичиг баримт, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлт, өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэх бол тухайн бүтээгдэхүүний мэдээлэл, схем, фото зураг гэх мэт мэдээллээр хангана.

3.5.Гадаад худалдааны гэрээнд барааг боловсруулах арга, үе шат, хугацаа, боловсруулалтын үйл ажиллагааны тухай нарийвчлан заасан байна.

3.6.Гадаадын барааг монголын бараатай нийлүүлж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, монголын барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах бол материалын орцын норм хэмжээг тогтоосон байна.

3.7.Гаалийн хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч боловсруулалтад ашиглагдсан барааны тооцоог аж ахуйн нэгж, байгууллагатай нийлж, гаалийн бүрдүүлэлт хийхээс өмнө баталгаажуулсан байна.

3.8.Баталгаажуулсан материалын тооцоог үндэслэн зохих горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

3.9.Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт боловсруулах барааны боловсруулалтын явцад гарсан хаягдал, үлдэгдэл бараанд мэдүүлэгчийн сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

3.10.Гаалийн байгууллага бүтээгдэхүүний орц, норм хэмжээг хянаж тогтоох, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын туслалцаа авна.

3.11.Гаалийн баталгаат бүс болон чөлөөт бүс хооронд барааг гаалийн итгэмжлэл авсан тээвэрлэгч тээвэрлэнэ.

3.12.Барааг гаалийн баталгаат бүс болон чөлөөт бүсээс өөр гаалийн байгууллагын хяналтад байгаа гаалийн баталгаат бүс болон чөлөөт бүс рүү шилжүүлэх тохиолдолд эхний гаалийн байгууллага гаалийн бүрдүүлэлтийг хийж, гаалийн мэдүүлгийг эцсийн бүрдүүлэлт хийх гаалийн байгууллагад гаалийн мэдээллийн автоматжуулсан системээр илгээж, барааг гаалийн хяналтад тээвэрлүүлнэ.

3.13.Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт оруулах бараа нь өөр гаалийн байгууллагын хяналтад байгаа тохиолдолд дараах байдлаар гаалийн бүрдүүлэлтийг хийж, гаалийн итгэмжлэл бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлүүлэн гаалийн хяналтад илгээнэ:

3.13.1.импортын манифесттай барааг гаалийн байгууллага хооронд бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэхдээ хаяг солих хүсэлтийг тээвэрлэгч тээврийн хэрэгслийн төрөл солигдох эсэхээс үл хамааран гаалийн удирдах төв байгууллагын хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгжид гаргаж шийдвэрлүүлэх;

3.13.2.гаалийн баталгаат бүсийн горимд байршуулсан барааг тухайн гаалийн байгууллагад мэдүүлж, гаалийн мэдүүлгийн “хүрэх газар” талбарт барааг оруулах гаалийн баталгаат үйлдвэрийн газрын кодыг нөхөн бичих.

Дөрөв. Гаалийн болон бусад татвар

4.1.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын горимд байршуулах болон гаалийн баталгаат үйлдвэрийн газраас гаргах барааны татвартай холбогдох асуудлыг Гаалийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.2-137.5, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

4.2.Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын горимд байршуулсан

бараанд дараах тохиолдолд холбогдох гаалийн болон бусад татвар ногдуулан хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ:

4.2.1. давагдашгүй хүчин зүйлээс бусад шалтгаанаар гаалийн баталгаат үйлдвэрийн газраас алдагдсан, устгагдсан;

4.2.2. энэ журмын 4.2.1-д зааснаас өөр бусад хэлбэрээр гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй захиран зарцуулсан.

4.3. Энэ журмын 4.2-т заасан тохиолдолд импортын татварыг зөрчил илрүүлсэн өдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, гаалийн тарифаар ногдуулан, хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ.

Тав. Бусад

5.1. Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын горимд байршуулах хугацаа хэтэрсэн барааг Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

5.2. Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тохиолдолд тухайн гаалийн баталгаат үйлдвэрийн газарт байршиж буй барааг Гаалийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2-т заасан хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд шилжүүлнэ.

5.3. Энэ журмын 5.2-т заасан хугацаанд барааг гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулаагүй тохиолдолд Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

5.4. Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан, хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн тохиолдолд үлдэгдэл барааг тоолж, гаалийн баталгаат үйлдвэрийн газар ажиллуулж байсан байршилд гаалийн хяналтад хадгална. Энэ тохиолдолд барааг гаалийн түр агуулахад байгаад тооцох ба түр агуулахад хадгалах хугацаа дуусгавар болохоос өмнө гаалийн хууль тогтоомжийн дагуу холбогдох горимд шилжүүлнэ.

*Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын
27-ны өдрийн А/489 дугаартай тушаалын 3 дугаар хавсралт*

ГААЛИЙН БАТАЛГААТ ҮЗЭСГЭЛЭНГИЙН ГАЗРЫН ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горим /цаашид “горим” гэх/-ыг хэрэгжүүлэхэд Зөвшөөрлийн тухай хууль, Гаалийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг мөрдөнө.

1.2.Горим сонгох, гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг үндэслэн барааг горимд байршуулах, горим дуусгавар болгох, гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт дараахь үйл ажиллагаа явуулна:

1.3.1.үзэсгэлэн гаргах;

1.3.2.туршилт хийх;

1.3.3.үйлчилгээ үзүүлэх;

1.3.4.барааны дээж, сорьц, загвар авах.

1.4.Хуулийн этгээд нь гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3, Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлд заасан бичиг баримтыг бүрдүүлэн гаалийн удирдах төв байгууллагад цахимаар ирүүлнэ.

1.5.Гаалийн удирдах төв байгууллага Гаалийн тухай хуулийн 138.1.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тохиолдолд Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн хяналт, тавьж ажиллах гаалийн байгууллага, гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын кодыг гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар батална.

1.6.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь баталгаат үзэсгэлэнгийн газрын зориулалт, талбайн хэмжээ, байршил өөрчлөхдөө шинэ талбайн хэмжээ, байрлал, барилга байгууламжийн зургийг холбогдох бусад материалын хамт бүрдүүлж, цахимаар хүсэлт гаргана. Энэ тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын гаалийн хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгж хүсэлтийг хүлээн авч хянаж, гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар шийдвэрлүүлнэ.

1.7.Хяналт тавих гаалийн байгууллага нь гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигчтэй горимын нөхцөл, шаардлагыг хангуулах зорилгоор гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

1.8.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт бараа оруулж, гаргах хаалганы дээд талд тэгш өнцөгт хэлбэртэй 1.0х0.60 метрийн харьцаатай, цагаан дэвсгэртэй самбар дээр хар хөх өнгөөр “Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар” гэсэн бичээстэй, зүүн дээд өнцөгт Монгол Улсын гаалийн байгууллагын бэлгэ тэмдэг бүхий олон нийтэд мэдэгдэхүйц таних тэмдэг байрлуулна.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт тавигдах техник, тоног төхөөрөмж, бараа материалыг энэ горимд байршуулна.

2.2.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар байгуулахад шаардагдах техник, тоног төхөөрөмж, бусад барааг энэ горимд байршуулахгүй бөгөөд мэдүүлэгчийн сонгосон бусад горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

2.3.Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

д	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт оруулах	720	шаардахгүй
2	Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт оруулах	721	шаардахгүй
Барааг гаалийн баталгаат бүсээс гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт оруулах:			
3	- баталгаат үзэсгэлэнгийн газраас	722	720, 723-725
	- гаалийн тусгай бүсээс	723	750-753, 758-765
4	Барааг чөлөөт бүсээс гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт оруулах	724	770, 771, 774-778
5	Гаалийн баталгаат агуулахаас гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт оруулах	725	700, 703, 704, 706, 707, 709

2.4.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрууд нь нэг эзэмшигчтэй байх тохиолдолд гаалийн бүрдүүлэлтийн горимын 722 кодоор бүрдүүлэлт хийнэ.

2.5.Гаалийн бүрдүүлэлтийн 722-725 горимд гадаадын барааг байршуулна.

2.6.Барааг гаалийн баталгаат бүс, чөлөөт бүсээс энэ горимд

байршуулахад өмнөх горимд байршсан хугацааг Гаалийн тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.1-д заасан хугацаанаас хасаж тооцно.

2.7.Энэ журмын 2.6-д заасны дагуу тооцож үзэхэд гаалийн баталгаат бүс, чөлөөт бүсэд байршсан нийт хугацаа нь Гаалийн тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.1-д заасан хугацаанаас хэтэрсэн тохиолдолд барааг энэ горимд байршуулахгүй.

2.8.Барааг горимд байршуулах хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө хугацаа сунгуулах хүсэлтийг гаалийн удирдах төв байгууллагын гаалийн хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгжид мэдүүлэгч эсхүл холбогдох этгээд гаргана.

2.9.Бараа гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт байх хугацаанд гэмтсэн, чанарын шаардлага хангахгүй болсон бол уг бараанд мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлт гаргуулж, гаалийн хууль тогтоомжийн дагуу гаалийн бүрдүүлэлт хийлгэнэ.

2.10.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын барааны бүртгэлийг оруулсан, гаргасан бараагаар хөтөлж, барааны хөдөлгөөний мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 03-ны өдрийн дотор хяналт тавьж ажилладаг гаалийн байгууллагад өгнө.

Гурав. Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт хяналт тавих

3.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн ажил үйлчилгээ нь гаалийн хяналтад байна.

3.2.Гаалийн баталгаат бүс болон чөлөөт бүс хооронд барааг гаалийн итгэмжлэл авсан тээвэрлэгч тээвэрлэнэ.

3.3.Барааг гаалийн баталгаат бүс болон чөлөөт бүсээс өөр гаалийн байгууллагын хяналтад байгаа гаалийн баталгаат бүс болон чөлөөт бүс рүү шилжүүлэх тохиолдолд эхний гаалийн байгууллага гаалийн бүрдүүлэлтийг хийж, гаалийн мэдүүлгийг эцсийн бүрдүүлэлт хийх гаалийн байгууллагад гаалийн мэдээллийн автоматжуулсан системээр илгээж, барааг гаалийн хяналтад тээвэрлүүлнэ.

3.4.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт оруулах бараа нь өөр гаалийн байгууллагын хяналтад байгаа тохиолдолд дараах байдлаар гаалийн бүрдүүлэлтийг хийж, гаалийн итгэмжлэл бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлүүлэн гаалийн хяналтад илгээнэ:

3.4.1.импортын манифесттай барааг гаалийн байгууллага хооронд бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэхдээ хаяг солих хүсэлтийг тээвэрлэгч тээврийн хэрэгслийн төрөл солигдох эсэхээс үл хамааран гаалийн удирдах төв байгууллагын хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгжид гаргаж шийдвэрлүүлэх;

3.4.2.гаалийн баталгаат бүсийн горимд байршуулсан барааг тухайн гаалийн байгууллагад мэдүүлж, гаалийн мэдүүлгийн “хүрэх газар” талбарт барааг оруулах гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын

кодыг нөхөн бичих.

Дөрөв. Гаалийн болон бусад татвар

4.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горимд байршуулах болон гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газраас гаргах барааны татвартай холбогдох асуудлыг Гаалийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.2-137.5, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

4.2.Баталгаат үзэсгэлэнгийн газрын горимд байршуулсан бараанд дараах тохиолдолд холбогдох гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ:

4.2.1.давагдашгүй хүчин зүйлээс бусад шалтгаанаар гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газраас алдагдсан, устгагдсан;

4.2.2.энэ журмын 4.2.1-т зааснаас өөр бусад хэлбэрээр гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй захиран зарцуулсан.

4.3.Энэ журмын 4.2-т заасан тохиолдолд импортын татварыг зөрчил илрүүлсэн өдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, гаалийн тарифаар ногдуулан, хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ.

Тав. Бусад

5.1.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын горимд байршуулах хугацаа хэтэрсэн барааг Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

5.2.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тохиолдолд тухайн гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газарт байршиж буй барааг Гаалийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2-т заасан хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд шилжүүлнэ.

5.3.Энэ журмын 5.2-т заасан хугацаанд барааг гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулаагүй тохиолдолд Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

5.4.Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан, хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн тохиолдолд үлдэгдэл барааг тоолж, гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар ажиллаж байсан байршилд гаалийн хяналтад хадгална. Энэ тохиолдолд барааг түр агуулахад байгаад тооцох ба түр агуулахад хадгалах хугацаа дуусгавар болохоос өмнө гаалийн хууль тогтоомжийн дагуу холбогдох горимд шилжүүлнэ.

Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/489 дугаартай тушаалын 4 дүгээр хавсралт

ГААЛИЙН БАТАЛГААТ БАРИЛГЫН ТАЛБАЙН ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гаалийн баталгаат барилгын талбайн горим /цаашид “горим” гэх/-ыг хэрэгжүүлэхэд Зөвшөөрлийн тухай хууль, Гаалийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг мөрдөнө.

1.2. Горим сонгох, гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг үндэслэн барааг горимд байршуулах, горим дуусгавар болгох, гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Гаалийн баталгаат барилгын талбайд дараахь үйл ажиллагаа явуулна.

1.3.1. барилгын материалын бүрэн бүтэн байдлыг шалгах;

1.3.2. барилгын материал боловсруулах;

1.3.3. барилга угсралтын үйл ажиллагаа явуулах.

1.4. Хуулийн этгээд нь гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3, Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлд заасан бичиг баримтыг бүрдүүлэн гаалийн удирдах төв байгууллагад цахимаар ирүүлнэ.

1.5. Гаалийн удирдах төв байгууллага Гаалийн тухай хуулийн 138 дугаар зүйлийн 138.1.4-т заасны дагуу үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тохиолдолд Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн хяналт, тавьж ажиллах гаалийн байгууллага, гаалийн баталгаат барилгын талбайн кодыг гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар батална.

1.6. Хяналт тавих гаалийн байгууллага нь гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигчтэй горимын нөхцөл, шаардлага хангуулах зорилгоор гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

1.7. Гаалийн баталгаат барилгын талбайд бараа оруулж, гаргах хаалганы дээд талд тэгш өнцөгт хэлбэртэй 1.0х0.60 метрийн харьцаатай, цагаан дэвсгэртэй самбар дээр хар хөх өнгөөр “Гаалийн баталгаат барилгын талбай” гэсэн бичээстэй, зүүн дээд өнцөгт Монгол Улсын гаалийн байгууллагын бэлгэ тэмдэг бүхий олон нийтэд мэдэгдэхүйц таних тэмдэг байрлуулна.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1.Барилгыг барихад шаардагдах үндсэн болон туслах материалыг Гаалийн тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.2-т заасны дагуу тухайн барилга бүрэн ашиглалтад оруулах хүртэлх хугацаанд энэ горимд байршуулна.

2.2.Тухайн барилгыг барихад ашиглах зорилгоор хилийн чанадаас оруулах техник, тоног төхөөрөмж, машин механизм, багаж хэрэгслийг энэ горимд байршуулахгүй бөгөөд мэдүүлэгчийн сонгосон бусад горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

2.3.Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

Д	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг гаалийн баталгаат барилгын талбайд оруулах	730	шаардахгүй
2	Барааг гаалийн баталгаат бүсээс гаалийн баталгаат барилгын талбайд оруулах :		
	гаалийн баталгаат агуулахаас	731	700, 703, 704, 706, 707, 709
	баталгаат барилгын талбайгаас	732	730-731, 733, 734
	гаалийн тусгай бүсээс	733	750-753, 758-765
3	Барааг чөлөөт бүсээс гаалийн баталгаат барилгын талбайд оруулах	734	770-771, 774-778

2.4.Гаалийн баталгаат барилгын талбайнууд нь нэг эзэмшигчтэй байх тохиолдолд гаалийн бүрдүүлэлтийн горимын 732 кодоор бүрдүүлэлт хийнэ.

2.5.Энэ горимд гадаадын барааг байршуулна.

Гурав.Гаалийн баталгаат барилгын талбайд хяналт тавих

3.1.Гаалийн баталгаат барилгын талбайд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн ажил үйлчилгээ нь гаалийн хяналтад байна.

3.2.Горимд байршуулах монголын барааг бүртгэж, хяналт тавина.

3.3.Гаалийн баталгаат бүс болон чөлөөт бүс хооронд барааг гаалийн итгэмжлэл авсан тээвэрлэгч тээвэрлэнэ.

3.4.Гаалийн баталгаат барилгын талбайд оруулах бараа нь өөр гаалийн байгууллагын хяналтад байгаа тохиолдолд дараах байдлаар гаалийн бүрдүүлэлтийг хийж, гаалийн итгэмжлэл бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлүүлэн гаалийн хяналтад илгээнэ:

3.4.1.импортын манифесттай барааг гаалийн байгууллага хооронд бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэхдээ хаяг солих хүсэлтийг

тээвэрлэгч тээврийн хэрэгслийн төрөл солигдох эсэхээс үл хамааран гаалийн удирдах төв байгууллагын хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгжид гаргаж шийдвэрлүүлэх;

3.4.2.гаалийн баталгаат бүсийн горимд байршуулсан барааг тухайн гаалийн байгууллагад мэдүүлж, гаалийн мэдүүлгийн “хүрэх газар” талбарт барааг оруулах гаалийн баталгаат барилгын талбайн кодыг нөхөн бичих.

Дөрөв. Гаалийн болон бусад татвар

4.1.Гаалийн баталгаат барилгын талбайн горимд байршуулах болон гаалийн баталгаат барилгын талбайгаас гаргах барааны татвартай холбогдох асуудлыг Гаалийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.2-137.5, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

4.2.Барилгын талбайн горимд байршуулсан бараанд дараах тохиолдолд холбогдох гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ:

4.2.1.давагдашгүй хүчин зүйлээс бусад шалтгаанаар гаалийн баталгаат агуулахаас алдагдсан, устгагдсан;

4.2.2.энэ журмын 4.2.1-д зааснаас өөр бусад хэлбэрээр гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй захиран зарцуулсан.

4.3.Энэ журмын 4.2-т заасан тохиолдолд импортын татварыг зөрчил илрүүлсэн өдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, гаалийн тарифаар ногдуулан, хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ.

Тав. Бусад

5.1.Барилга угсралтын ажил дууссаны дараа ашиглагдаагүй үлдсэн барааг Гаалийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулна.

5.2.Энэ журмын 5.1-д заасан хугацаанд гаалийн бүрдүүлэлт хийлгээгүй тохиолдолд Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

5.3.Гаалийн баталгаат барилгын талбайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тохиолдолд тухайн гаалийн баталгаат барилгын талбайд байршиж буй барааг Гаалийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2-т заасан хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд шилжүүлнэ.

5.4.Энэ журмын 5.3-т заасан хугацаанд барааг гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулаагүй тохиолдолд Гаалийн тухай хуулийн 298 дугаар зүйлийн 298.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

*Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын
27-ны өдрийн А/489 дугаартай тушаалын 5 дугаар хавсралт*

ТАТВАРГҮЙ БАРААНЫ ДЭЛГҮҮРИЙН ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Татваргүй барааны дэлгүүрийн горим /цаашид горим гэх/-ыг хэрэгжүүлэхэд Зөвшөөрлийн тухай хууль, Гаалийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг мөрдөнө.

1.2.Горим сонгох, гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг үндэслэн барааг горимд байршуулах, горим дуусгавар болохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3.Мэдүүлэгч горимыг сонгох бөгөөд гаалийн бүрдүүлэлтийн горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.

1.4.Гаалийн удирдах төв байгууллага нь Гаалийн тухай хуулийн 138.3-т заасны дагуу дуудлага худалдааны үндсэн дээр татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоно.

1.5.Хяналт тавих гаалийн байгууллага нь татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигчтэй Гаалийн тухай хуульд заасан горимын нөхцөл, шаардлагыг хангуулах зорилгоор гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

1.6.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрөлд заасан хот, боомтод дэлгүүрийн байршлаа өөрчилж болох бөгөөд энэ тохиолдолд шинэ талбайн хэмжээ, байрлал, барилга байгууламжийн зургийг холбогдох бусад материалын хамт бүрдүүлж, гаалийн удирдах төв байгууллагын хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлэн хянуулж, шийдвэрлүүлнэ.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1.Горимд Гаалийн тухай хуулийн 170.1.1 - 170.1.6 дахь заалтад зааснаас бусад барааг байршуулна.

2.2.Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

д	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Шаардах өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг татваргүй барааны дэлгүүрт оруулах	740	шаардахгүй
2	Монголын барааг татваргүй барааны дэлгүүрт оруулах	741	шаардахгүй

3	Барааг гаалийн баталгаат агуулахаас татваргүй барааны дэлгүүрт оруулах	742	700, 703, 705
4	Барааг татваргүй барааны дэлгүүрээс татваргүй барааны дэлгүүрт шилжүүлэх	743	740-742
5	Зөвшөөрөл нь хүчингүй болсон татваргүй барааны дэлгүүрээс зөвшөөрөл нь хүчинтэй үйл ажиллагаа явуулж буй татваргүй барааны дэлгүүрт оруулах	744	740-743
6	Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг улс хоорондын тээврийн зорчигчид зориулан борлуулахаар оруулах	745	шаардахгүй
7	Монголын барааг улс хоорондын тээврийн зорчигчид зориулан борлуулахаар оруулах	746	шаардахгүй
8	Барааг гаалийн баталгаат агуулахаас улс хоорондын тээврийн зорчигчид зориулан борлуулахаар оруулах	747	700, 703, 705

2.3.Гаалийн бүрдүүлэлтийн горимын 742 кодоор бүрдүүлэлт хийхэд татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигчийн гаалийн баталгаат агуулахад оруулсан бараа хамаарна.

2.4.Татваргүй барааны дэлгүүрт худалдагдсан бараанд бүрдүүлэлтийн горимын 314 кодоор бүрдүүлэлт хийлгэх тохиолдолд хэлцлийн 390 код, бүрдүүлэлтийн горимын 145 кодоор бүрдүүлэлт хийлгэх тохиолдолд хэлцлийн 391 кодыг сонгоно.

2.5.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч өөрийн нэг дэлгүүрээс нөгөө дэлгүүрт бараа шилжүүлэхэд 743 кодоор гаалийн бүрдүүлэлт хийлгэнэ.

2.6.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь хүчингүй болсон дэлгүүрийн барааг зөвшөөрөл нь хүчинтэй үйл ажиллагаа явуулж буй татваргүй барааны дэлгүүрт оруулахад горимын 744 кодоор гаалийн бүрдүүлэлт хийлгэнэ.

2.7.Татваргүй барааны дэлгүүрт оруулах бараа нь өөр гаалийн байгууллагын хяналтад байгаа тохиолдолд дараах байдлаар гаалийн бүрдүүлэлтийг хийж, гаалийн итгэмжлэл бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлүүлэн гаалийн хяналтад илгээнэ:

2.7.1.импортын манифесттай барааг гаалийн байгууллага хооронд бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэхдээ хаяг солих хүсэлтийг тээвэрлэгч тээврийн хэрэгслийн төрөл солигдох эсэхээс үл хамааран гаалийн удирдах төв байгууллагын хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгжид гаргаж шийдвэрлүүлэн;

2.7.2.гаалийн баталгаат бүсийн горимд байршуулсан барааг тухайн гаалийн байгууллагад мэдүүлж, гаалийн мэдүүлгийн “хүрэх газар” талбарт татваргүй барааны дэлгүүрийн кодыг нөхөн бичих.

2.8.Улс хооронд зорчигч тээвэрлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн горимын 745, 746 болон 747 кодоор бүрдүүлэлт хийлгэхдээ хяналт тавьж ажиллах гаалийн газар, хороо болон гаалийн баталгаат агуулах эзэмшигчтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан байна. Горимд байршуулсан барааг гаалийн баталгаат агуулахад хадгалуулах бөгөөд гаалийн бүрдүүлэлтийн горимын 912 кодоор бүрдүүлэлт хийлгэж, гаалийн хяналтад тээвэрлэн, улс хоорондын тээврийн төлбөртэй үйлчилгээнд гаргана.

Гурав.Гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардах мэдээлэл, бичиг баримт

3.1.Гаалийн бүрдүүлэлтийн горимд мэдүүлэгч дараах бичиг, баримтыг цахимаар татаж гаалийн бүрдүүлэлтийг хийлгэнэ. Үүнд:

3.1.1.гаалийн бүрдүүлэлтийн горимын 740-744 кодоор бүрдүүлэлт хийлгэхэд татваргүй барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрлийг зөвшөөрлийн нэгдсэн сангаас;

3.1.2.гаалийн бүрдүүлэлтийн горимын 745-747 кодоор бүрдүүлэлт хийлгэхэд улс хооронд тээвэрлэлт хийх зөвшөөрлийг зөвшөөрлийн нэгдсэн сангаас;

3.1.3.зөвшөөрөл эзэмшигч хилийн чанад дахь бараа нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг гаалийн гэрээ бүртгэлийн програмаас;

3.1.4.барааны бүртгэлд GS1 системийг нэвтрүүлсэн байх бөгөөд горимд байршуулах барааны баркодыг бараа бүртгэлийн нэгдсэн системээс;

3.1.5.гаалийн бүрдүүлэлтийн горимын 741 кодоор бүрдүүлэлт хийлгэхэд Монгол Улсад үйлдвэрлэсэн, чанар, стандартын шаардлага хангасан, тохирлын гэрчилгээг бараа бүртгэлийн нэгдсэн системээс.

3.2.Татваргүй барааны дэлгүүрийн барааны шошго эсхүл хайрцаг дээр “Mongolian duty not paid” гэсэн бичигтэй дахин салгах боломжгүй дардас, согтууруулах ундааны савлагаанд “MONGOLIAN DUTY FREE” загвар бүхий тэмдгийг дахин салгах боломжгүй наасан байна.

Дөрөв.Гаалийн бүрдүүлэлтийн горимд мөрдөх баталгаа

4.1.Татваргүй барааны дэлгүүрийн горимд байршуулах болон татваргүй барааны дэлгүүрээс хилийн чанадад гаргах барааны татвартай холбогдох асуудлыг Гаалийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.2 - 137.5 дахь хэсэг, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалтад заасны дагуу шийдвэрлэнэ.

4.2.Хилийн боомтод гарах урсгалд ажилладаг дэлгүүр зорчигчдод архины зүйлс 3 литр, дарс 3 литр, шар айраг 3 литр, янжуур тамхи 400 ш, сигар 50 ш, задгай тамхи 250 граммаас илүүгүй хэмжээгээр гаалийн болон бусад татваргүй худалдана.

4.3.Гаалийн нутаг дэвсгэрийн гүнд байрлах дэлгүүр нь Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын болон олон улсын байгууллагын дипломат эрх ямба, дархан эрх эдлэх албан тушаалтны хувийн хэрэглээнд архины зүйлс 3 литр, дарс 3 литр, шар айраг 3 литр, янжуур 400 ширхэг, сигар, навчин тамхи 50 ширхэг, задгай тамхи 250 граммаас илүүгүй хэмжээгээр гаалийн болон бусад татваргүй худалдана.

4.4.Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын болон олон улсын байгууллагын захиалгаар тусгай үйлчилгээ явуулах тохиолдолд холбогдох нот бичиг, албан ёсны хүсэлтийг худалдан авах барааны тоо хэмжээтэй жагсаалтын хамт хяналт тавьж буй гаалийн байгууллагад ирүүлнэ. Хяналт тавьж буй гаалийн байгууллага бичиг баримтыг хянаж, шийдвэрлэнэ.

4.5.Гадаад улсаас Монгол улсад суугаа өргөмжит консул татваргүй барааны дэлгүүрээр үйлчлүүлэхгүй.

4.6.Татваргүй барааны дэлгүүрт энэ журамд зааснаас өөрөөр, захиалгаар, загварын, зээлийн, нэмэгдэл үйлчилгээний болон хаягаар үйлчлэх замаар худалдахгүй.

4.7.Барааны үнийг үндэсний валютаар тогтоох бөгөөд гадаад валютаар худалдаалах тохиолдолд Монголбанкнаас зарласан тухайн өдрийн албан ханшийг баримтлана.

4.8.Татваргүй барааны дэлгүүрийн горимд байршуулсан бараанд дараах тохиолдолд холбогдох гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ:

4.8.1.давагдашгүй хүчин зүйлээс бусад шалтгаанаар татваргүй барааны дэлгүүрээс алдагдсан, устгагдсан;

4.8.2.энэ журмын 4.2-4.4-т зааснаас бусад этгээдэд худалдан борлуулсан.

4.9.Энэ журмын 4.8-д заасан тохиолдолд импортын татварыг зөрчил илрүүлсэн өдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, гаалийн тарифаар ногдуулан, хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ.

Тав.Татваргүй барааны дэлгүүрт тавих гаалийн хяналт

5.1.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн бараа, ажил, үйлчилгээ нь гаалийн хяналтад байх бөгөөд гаалийн байгууллага барааг аль ч үед шалгах эрхтэй байна.

5.2.Татваргүй барааны дэлгүүр нь теле хяналтын камерыг бараа, ажил, үйлчилгээ бүхэлдээ харагдахаар байрлуулж, тус бүрийг гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбуулсан байхаас гадна борлуулсан барааны мэдээллийг бодит цагийн горимоор гаалийн байгууллагад цахимаар илгээнэ.

5.3.Татваргүй барааны дэлгүүрт хяналт тавихаар томилогдсон гаалийн албан хаагч нь гаалийн мэдээллийн автоматжуулсан системд хүлээн авсан дэлгүүрийн борлуулалтын мэдээллийг, теле хяналтын нэгдсэн системтэй уялдуулан цахим системд суурилсан гаалийн хяналтыг хэрэгжүүлнэ.

5.4.Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа явуулах этгээд нь дэлгүүрийг нээж, хаахдаа хяналт тавихаар хуваарилагдсан гаалийн улсын байцаагчид урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авсны дараа гаалийн ломбо бүртгэх системд ломбоны дугаарыг илгээж, теле хяналтын камерт ломбоны дугаарыг тод харуулан ломбыг авах болон зүүнэ.

5.5.Хяналт тавихаар хуваарилагдсан гаалийн улсын байцаагч шаардлагатай тохиолдолд татваргүй барааны дэлгүүрт тооллого, үзлэг, шалгалт хийж болно. Тооллого, үзлэг, шалгалт хийхдээ дэлгүүрийн холбогдох этгээдийг байлцуулан тэмдэглэл хөтлөнө.

Зургаа. Горим дуусгавар болох

6.1.Горимд байршуулсан барааг дараах байдлаар борлуулснаар, эсхүл өөр горимд байршуулснаар татваргүй барааны дэлгүүрийн горим дуусгавар болно:

6.1.1.хилийн боомтод гарах урсгалд ажилладаг дэлгүүр нь зорчигчийн гадаад паспортын дугаараар хил хамгаалах байгууллагын хилээр нэвтрэх зорчигчийн мэдээллийн сангаас татаж, борлуулсан барааны нэр, баркод, тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдээллийг бодит цагийн горимоор гаалийн байгууллагад цахимаар илгээснээр;

6.1.2.гаалийн нутаг дэвсгэрийн гүнд байрлах дэлгүүр нь Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын болон олон улсын байгууллагын дипломат эрх ямба, дархан эрх эдлэх албан тушаалтны паспорт, эсхүл дипломат үнэмлэхийг үндэслэн борлуулсан барааны нэр, баркод, тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдээллийг бодит цагийн горимоор гаалийн байгууллагад цахимаар илгээснээр.

6.2.Татваргүй барааны дэлгүүрт худалдагдсан барааг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгож нэгтгэн, дараа сарын 03-ны өдрийн дотор гадаадын барааг гаалийн бүрдүүлэлтийн горимын 314, монголын барааг гаалийн бүрдүүлэлтийн горимын 145 кодоор гаалийн байгууллагад мэдүүлж, хялбарчилсан бүрдүүлэлт хийлгэнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 7428 дугаарт бүртгэв.

**МОНГОЛ УЛСЫН
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ**

2025 оны 10 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 237

Улаанбаатар
хот

**“ГАДАРГЫН УСНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ”
/БНБД 33-10-25/ БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ ШИНЭЧЛЭН
БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг,

Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг болох “Гадаргын усны үндсэн үзүүлэлтийг тодорхойлох” /БНБД 33-10-25/ барилгын норм ба дүрмийг хавсралт ёсоор баталж, 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Батлагдсан барилгын норм ба дүрмийг хэм хэмжээний актын нэгдсэн санд зохих журмын дагуу бүртгүүлэх, мөрдөж эхлэх хугацаанаас өмнө хэвлэн олшруулж холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдээлэл хүргэх, сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулахыг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ /Т.Пүрэвхатан/-т, энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газар /Д.Энхбаатар/-т тус тус даалгасугай.

САЙД

Э.БАТ-АМГАЛАН

Энэ тушаалын хавсралтыг доорх линкээр үзнэ үү.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17434330832262>

**МОНГОЛ УЛСЫН
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ**

2025 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 244

Улаанбаатар
хот

БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтад заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу “Байр зүйн болон дэвсгэр зураглалын ажил” /БНБД 11-106-25/ барилгын норм ба дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2.Батлагдсан барилгын норм ба дүрмийг хэвлүүлэх, сурталчлах, нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар /А.Энхманлай/, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ /Т.Пүрэвхатан/-т, энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газар /О.Одбаяр/-т тус тус даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан “Дүрэм батлах тухай /1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн зураглалын ажил БД 11-106-08 барилгын дүрэм/” Барилга, хот байгуулалтын сайдын 2008 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 104 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Э.БАТ-АМГАЛАН

Энэ тушаалын хавсралтыг доорх линкээр үзнэ үү.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17434331765452&showType=1>

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 7430 дугаарт бүртгэв.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар А/1660

Даланзадгад сум

ЦАХИМ ТОГЛООМЫН ГАЗАР, ИНТЕРНЭТ КАФЕД ТАВИГДАХ ШААРДЛАГА, АЖИЛЛАХ ЦАГИЙН ХУВААРИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа цахим тоглоомын газар, интернэт кафед тавигдах шаардлага, ажиллах цагийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Ж.Мөнхсүлд), Өмнөговь аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс (Б.Мөнхтуяа)-т, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ЭНХБАТ

*Аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын
11-ний өдрийн А/1660 дугаар захирамжийн хавсралт*

**ЦАХИМ ТОГЛООМЫН ГАЗАР, ИНТЕРНЭТ
КАФЕД ТАВИГДАХ ШААРДЛАГА, АЖИЛЛАХ ЦАГИЙН ХУВААРЬ**

1. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь цахим тоглоом, интернэт кафены үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, ажиллах цагийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулах замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оршино.

1.2.Цахим тоглоом, интернэт кафены үйлчилгээ эрхлэх иргэн, хуулийн этгээд нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж болон энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

2. Ажлын байрны шаардлага

2.1.Цахим тоглоомын газар, интернэт кафены газруудын үйл ажиллагаа явуулж буй ажлын байр нь холбогдох стандарт болон эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэхэд Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг гаргуулсан байна.

2.2.Цахим тоглоомын газар, интернэт кафены газар ажиллуулж буй иргэн, хуулийн этгээд нь харьяа сумын Засаг даргын Тамгын газарт бүргүүлнэ.

2.3.Үйлчилгээ үзүүлж байгаа ажлын байр нь гадна талдаа хаяг, цагийн хуваарийг байршуулсан байх ба бүртгэлийн гэрчилгээ, ажиллах дотоод журам, үйлчилгээний үнийн тариф, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх анхааруулга бүхий самбар (тамхи татах, согтууруулах ундааны зүйл, мансууруулах бодис хэрэглэхийг хатуу хориглосон тэмдэг, тэмдэглэгээ зэрэг)-ыг үйлчлүүлэгчдэд харагдахуйц газар ил байрлуулна.

2.4.Цахим тоглоомын газар, интернэт кафены газар нь 18 наснаас дээш насны иргэдэд 7/24 цагаар үйлчилж болно.

2.5.9-18 хүртэлх насны хүүхдэд зуны улиралд (04 дүгээр сарын 1-нээс 10 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацаа) 20.00 цаг хүртэл, өвлийн улиралд (10 дугаар сарын 1-нээс 04 дүгээр сарын 1-нийг хүртэлх хугацаа) 18.00 цаг хүртэл үйлчлэх бөгөөд өдөрт нэг хүүхдэд 2 цагаас илүүгүй хугацаагаар үйлчилнэ.

2.6.Цахим тоглоомын газар, интернэт кафены газрын үйлчилгээний ажилтан нь мэдээллийн технологийн мэдлэгтэй, энэ журмын 5.1-д заасан сургалтад хамрагдсан насанд хүрсэн иргэн байна.

2.7.Ажлын байрны гадна болон дотор орчинд стандартад нийцсэн хяналтын камер суурилуулсан байх бөгөөд мэдээлэл хадгалах сервер

нь 21-ээс дээш хоногийн бичлэгийг хадгалах хүчин чадалтай байна.

2.8.Холбогдох хууль тогтоомжоор хориглосон цахим хуудсыг ашиглахгүй байх тохиргооны программ хангамжийг компьютеруудад заавал суулгасан байна.

2.9.Энэхүү журамд заасан чиглэлээр үйлчилгээ эрхэлж буй иргэн, хуулийн этгээд нь үйлчлүүлж байгаа хэрэглэгчдийн бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх ба эрх бүхий байгууллагын шаардсаны дагуу шаардлагатай мэдээллийг гаргаж өгнө.

3. Хориглох зүйлс

3.1.Цахим тоглоомын газар нь дараах үйл ажиллагааг явуулахыг хориглоно:

3.1.1.орон сууцны нэг давхар, зоорины давхарт үйл ажиллагаа явуулах;

3.1.2.хуулиар хориглосон мөрийтэй тоглоом (казино) тоглуулах, түүнийг зохион байгуулах, терроризм, аллага, хүчирхийлэл, садар самуун сурталчилсан тоглоом тоглуулах;

3.1.3.цахим тоглоомын үйлчилгээгээр 9 насанд хүрээгүй хүүхдэд үйлчлэх;

3.1.4. бичиг баримт, эд зүйлс барьцаалан иргэдэд үйлчлэх;

3.1.5.согтуурсан болон мансуурсан иргэнд үйлчлэх;

4. Бусад

4.1.Энэ журамд заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээд нь хүүхдийн эрх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэдтэй харилцах харилцаа болон тоглоомонд донтон тоглох зэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагын сургалтад хамрагдсаныг нотлох баримт бичигтэй байна.

4.2.Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулна.

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар А/490

Улаанбаатар
хот

ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэг, 268¹ дугаар зүйлийн 268¹.1.1 дэх заалт, 269¹ дүгээр зүйлийн 269¹.1.1 дэх заалт, 270¹ дугаар зүйлийн 270¹.1.4 дэх заалт, 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.1, 271¹.1.2, 271¹.1.17 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 10/10 дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/281 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Ачааны манифест нөхөн бичих, хянах, бүртгэх журам”-ын 10 дугаар зүйлийн 10.3, 10.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.3.”ХШ ГУАБ зөвшөөрсөн” төлөвт оруулсан манифестын хүснэгтийн 23, 25, 26, 28, 29, 30, 31 дүгээр талбарт нөхөж бичсэн барааны нэр, БТКУС-ийн ангилал, баглаа боодлын тоо, цэвэр жин, бохир жин, барааны үнэ, валютын кодны мэдээлэлд гаалийн удирдах төв байгууллагын хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгжийн зөвшөөрлөөр өөрчлөлт оруулна.”

“10.4.Энэхүү журмын 10.3-т зааснаас бусад талбарын мэдээлэлд оруулах өөрчлөлтийг манифестыг “ХШ ГУАБ зөвшөөрсөн” төлөвт шилжүүлсэн гаалийн байгууллагын хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгжийн дарга оруулна. Дээрх өөрчлөлтийг оруулахдаа CAIS-т холбогдох нотлох баримтыг хавсаргана.”

2.Энэхүү журамд дор дурдсан найруулга бүхий 5.17, 5.18, 5.19, 5.20 дахь заалтыг нэмсүгэй.

“5.17.Хилийн гаалийн байгууллага нь гаалийн хилээр оруулах улс хоорондын шуудан илгээмжийн дагалдах бичиг баримтыг гаалийн хяналтад авч, манифестыг бүрдүүлэлт хийх гаалийн хяналтын бүс рүү гаалийн мэдээллийн автоматжуулсан системээр илгээнэ.”

“5.18.Хилийн гаалийн байгууллагаас гаалийн мэдээллийн автоматжуулсан системээр илгээсэн манифестын мэдээллийг гүний гаалийн байгууллагын гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч шалган, гаалийн хяналтын бүсэд оруулах зөвшөөрөл өгч, хяналтад авна.”

“5.19.Гаалийн мэдээллийн автоматжуулсан системээс хуваарилсан манифестыг хүлээн авсан гаалийн улсын байцаагч тээврийн баримтын дугаараар системээс манифестада хавсаргасан илгээмж хүлээн авагчийн мэдээллийг татаж, байр ачааны тоо, жинг нягтлан бүх шуудан илгээмжийн бар кодыг уншуулан, рентгенээр шалгана. Дээрх шалгалтын үр дүн болон дагалдах бичиг баримтын мэдээлэлд үндэслэн гаалийн байгууллагаас шалгах шуудангийн илгээмжийг “YES”, хүлээн авагчид олгох шуудангийн илгээмжийг “NO” төлөвт оруулна.”

“5.20.Гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч “NO” төлөвт оруулсан шуудан илгээмжийг хянаж, шалгах үндэслэлтэй тохиолдолд тухайн илгээмжийн төлөвийг “YES” төлөвт шилжүүлж, зөвшөөрнө.”

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, бүрдүүлэлтийн газар (Б.Даваасүрэн)-т даалгасугай.

4.Энэ тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг харьяа гаалийн, хорооны дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ

ТЭМДЭГЛЭЛ